



САНГИЙН ЯАМ

ШИЛЭН ДАНСНЫ ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮР ДАГАВРЫН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

**Улаанбаатар хот
2021 он**

АГУУЛГА

УДИРТГАЛ

Үнэлгээ хийх үндсэн асуудал

НЭГ. ТӨЛӨВЛӨХ ҮЕ ШАТ

- 1.1. Үнэлгээ хийх шалтгаан
- 1.2. Үнэлгээ хийх хүрээ
- 1.3. Үнэлгээ хийх шалгуур үзүүлэлт
- 1.4. Харьцуулах хэлбэрийг сонгох
- 1.5. Шалгуур үзүүлэлтийн томъёолол
- 1.6. Мэдээлэл цуглуулах арга сонгох

ХОЁР. ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ

ГУРАВ. ҮНЭЛЭХ ҮЕ ШАТ, ЗӨВЛӨМЖ, ДҮГНЭЛТ

- 3.1. Мэдээллийг үнэлсэн байдал:
- 3.2. Шалгуур үзүүлэлт, харьцуулах хэлбэрийг ашиглан үнэлсэн байдал.
 - 3.2.1. 3 дугаар зүйлийн (субъектийн) хэрэгжилтийн үнэлгээний талаар:
 - 3.2.2. 3 дугаар зүйлийн (мэдээлэл) хэрэгжилтийн үнэлгээний талаар:
 - 3.2.3. 3 дугаар зүйлийн 3.4 хэсгийн хэрэгжилтийн үнэлгээний талаар:
 - 3.2.4. 6 дугаар зүйлийн хэрэгжилтийн үнэлгээний талаар:
 - 3.2.5. 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсгийн хэрэгжилтийн үнэлгээний талаар:
 - 3.2.6. 10 дугаар зүйлийн хэрэгжилтийн үнэлгээний талаар:

УДИРТГАЛ

2014 онд батлагдсан Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын зургадугаар хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”-ын дагуу үнэлгээ хийв.

Үнэлгээ хийх зорилт нь Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн бодит байдалд дүн шинжилгээ хийх, тулгарч байгаа хүндрэл бэрхшээлтэй асуудал, нийгэмд үзүүлж буй эерэг, сөрөг нөлөөллийг илрүүлэх, цаашид хуулийг зохистой, үр дүнтэй хэрэгжүүлэх, Монгол Улсын холбогдох бусад хууль тогтоомжтой уялдуулах боломжит хувилбарыг тодорхойлоход оршино.

Үнэлгээг дараахь үе шаттайгаар хийж гүйцэтгэлээ. Үүнд:

1. Төлөвлөх үе шат
2. Хэрэгжүүлэх үе шат
3. Үнэлэх үе шат

НЭГ.ТӨЛӨВЛӨХ ҮЕ ШАТ

1.1.Үнэлгээ хийх шалтгаан

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлд “Монгол Улсын иргэн дараахь үндсэн эрх, эрх чөлөөг баталгаатай эдэлнэ: 17/төр, түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалбал зохих нууцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах эрхтэй. Хүний эрх, нэр төр, алдар хүнд, улсыг батлан хамгаалах, үндэсний аюулгүй байдал, нийгмийн хэв журмыг хангах зорилгоор задруулж үл болох төр, байгууллага, хувь хүний нууцыг хуулиар тогтоон хамгаална;” гэж тодорхойлсон.

Монгол Улсын Их хурлаас 2014 оны 7 дугаар сарын 1-ний өдөр Шилэн дансны тухай хуулийг баталж, 2015 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн нь Монгол Улсын Үндсэн хуулиар олгогдсон дээрх эрхийг хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх хуулиудын нэг болжээ.

Гэвч 7 жилийн өмнө батлагдсан энэхүү хуулийг хэрэгжүүлэх явцад улс төр, нийгэм, эдийн засгийн харилцаа өргөжин тэлж, улмаар нийгмийн хөгжлийг даган нийгмийн харилцааг зохицуулах хууль тогтоомжууд шинэчлэгдэх үйл явц үргэлжилсээр байна. Түүнчлэн иргэдийн эрх зүйн болон мэдээллийн технологийн мэдлэг дээшилж, тэдний мэдээлэл авах эх сурвалж, боломж ихээр нэмэгдсэн. Эдгээр хүчин зүйлийн улмаас Шилэн дансны тухай хууль нь эрх зүйн шинэчлэл, нийгмийн хэрэгцээ шаардлагаас хоцорч хуулийн хэд хэдэн заалт хэрэгжих боломж хязгаарлагдаж байгаа нь хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх зайлшгүй шаардлагатайг харуулж байна.

Монгол Улсын Үндсэн хууль, Зөрчлийн тухай хууль, Мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Захиргааны ерөнхий хууль, Төрийн албаны тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Төсвийн тухай хууль, Засгийн газрын тусгай сангийн тухай хууль, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль, Төрийн болон албаны нууцын тухай хууль гэх зэрэг нийгмийн харилцааг зохицуулсан олон хууль тогтоомж өөрчлөгдөн шинэчлэгдэхийн зэрэгцээ эдгээрт нийцүүлэн Шилэн дансны тухай хуулийн зохицуулалтад хамаарах үйлчлэх хүрээ улам бүр өргөжин тэлэх хэрэгцээ шаардлагыг бий болгож байна.

Шилэн дансны тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсэгт “Шилэн дансны тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Төсвийн тухай хууль, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ” гэж заасан.

Гэвч Шилэн дансны тухай хууль нь хэрэгжилтийн хувьд Монгол Улсын 20 гаруй хуультай холбоотой байгаа юм. Үүнд:

1. Монгол Улсын Үндсэн хууль,
2. Төсвийн тухай хууль,
3. Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль,
4. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
5. Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль,
6. Зөрчлийн тухай хууль,
7. Төрийн албаны тухай хууль,
8. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль,
9. Төрийн болон албаны нууцын тухай хууль,
10. Засгийн газрын тусгай сангийн тухай,
11. Концессын тухай,
12. Төсвийн тогтвортой байдлын тухай,
13. Төрийн аудитын тухай,
14. Аудитын тухай,
15. Нягтлан бодох бүртгэлийн тухай,
16. Төрийн хяналт шалгалтын тухай,
17. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай,
18. Компанийн тухай,
19. Үнэт цаасны зах зээлийн тухай хууль,
20. Банкны тухай хууль,
21. Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль,
22. Даатгалын тухай хууль,

Эдгээр хуулиас гадна, эрх зүйн хүрээний бусад холбогдох тогтоол, тушаал шийдвэр, дүрэм, журам зэрэг баримт бичгийн нийцэл, давхардал, зөрчлийг нарийвчлан үзэх шаардлага гарч байна.

Түүнчлэн Улсын Их Хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 3 дугаар бүлгийн 3.1.12-д “Төсөв, санхүүгийн нэгдсэн цахим систем нэвтрүүлж, төрийн үйлчилгээг шуурхай, үр ашигтай болгож, гадаадын зээл, тусламж, төсвийн урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг ил тод, хэмнэлттэй зарцуулах нөхцөл бүрдүүлнэ” гэж заасан.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор Монгол Улсын Засгийн газраас 2014 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн 384-р тогтоолоор “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журам”-ыг баталсан бол Засгийн газрын 2016 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн 29 дүгээр тогтоолоор нийт 23 хуудас хавсралт бүхий “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ыг шинэчлэн баталж өнөөдрийн байдлаар хүчин төгөлдөр мөрдөгдөж байна.

Энэ хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор шилэн дансны нэгдсэн цахим хуудас ажиллуулах, түүнийг ашиглаж эхлэх хугацааг энэ хуулийн хэрэгжилтийн байдлыг харгалзан Засгийн газар 2016 оны 06 дугаар сарын 30-ны өдрөөс өмнө байхаар тогтоосон бөгөөд уг нэгдсэн цахим хуудсыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага эрхлэн хөтлөхөөр заасан.

Улмаар олон нийтэд мэдээллийг хүргэх “шилэн дансны нэгдсэн цахим хуудас” (цаашид ШДНЦХ гэх) www.shilendans.gov.mn цахим хуудас 2015 оны 5 дугаар сарын 13-ны өдрөөс 6 сарын хугацаанд туршин нэвтрүүлсэн бөгөөд өнөөдрийн байдлаар Сангийн яам хуулийн дагуу тус системийг эрхлэн хөтөлж байна.

Монгол Улсын Шилэн дансны тухай хууль нь нийт 3 бүлэг 11 зүйлтэй. Хуульд 2014 оны 10 дугаар сарын 16-ны өдөр нэмэлт өөрчлөлт, 2015 оны 12 дугаар сарын 04-ний өдөр болон 2016 оны 2 дугаар сарын 05-ны өдөр тус тус өөрчлөлт орж нийт 3 удаагийн нэмэлт, өөрчлөлтийг хууль батлагдсанаас хойш хийсэн байна.

2014 оны 10 дугаар сарын 16-ны өдөр орсон хуулийн нэмэлт өөрчлөлтийн хувьд: Эдийн засгийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага татан буугдсантай холбоотойгоор дараахь мэдээллийг Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага гаргаж байхаар хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсан.

- концессын зүйлийн жагсаалт болон түүнд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг батлагдсанаас нь хойш долоо хоногийн дотор (6.5.8);
- концессын гэрээ болон түүнд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг гэрээ байгуулагдсанаас нь хойш долоо хоногийн дотор (6.5.9);
- концессын гэрээ байгуулсан тухай бүрд концесс эзэмшигч, түүний байгууллагын нууцад хамаарахаас бусад мэдээлэл, концессын зүйл, гүйцэтгэх ажил, үзүүлэх үйлчилгээний талаарх мэдээллийг долоо хоногийн дотор; (6.5.10).
- хөрөнгө оруулалтыг санхүүжүүлэх зорилгоор гаргасан Засгийн газрын гадаад үнэт цаасны мэдээллийг улирал бүр (6.5.11);
- улсын төсвийн нэгдсэн үзүүлэлтийг макро эдийн засгийн үзүүлэлт, холбогдох бусад үзүүлэлттэй уялдуулсан судалгаа, тооцоог улирал бүр (6.5.12).

2015 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн хуулиар Шилэн дансны тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсгийг “Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ” гэж өөрчлөн найруулсан.

2016 оны 2 дугаар сарын 05-ны өдрийн хуулиар Хүний хөгжлийн сантай холбоотойгоор Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.2.1 дэх заалтын “сан, Хүний хөгжил” гэснийг, 6 дугаар зүйлийн 6.5.1 дэх заалтын “төсөв, Хүний хөгжил сангийн” гэснийг тус тус хассан.

Шилэн дансны тухай хуулийн 8 дугаар зүйлд заасны дагуу Үндэсний аудитын газраас жил бүр шилэн дансны хэрэгжилтэд хөндлөнгийн аудит хийж, холбогдох дүгнэлт гарган, зөвлөмжийг Засгийн газар, Сангийн сайдад хүргүүлж ирсэн байна.

Төрийн аудитын байгууллагаас 2015-аас 2021 онд хийгдсэн аудитын тайлангуудад тусгасан эрх зүйн зөрчил болон хэрэгжилт хангалтгүй талаар дүгнэлт, зөвлөмжийн талаар:

ҮАГ- НАГ/2015/04-НА кодтой аудитаар өгсөн зөвлөмж:

1. Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.2-т заасан байгууллагууд нь хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2-т заасан мэдээллийг тогтоосон хугацаанд 6.3-т заасан ангиллын дагуу мэдээлэх үүрэгтэй бөгөөд эдгээр байгууллагуудын хувьд харьяалах дээд байгууллагуудаас нь төсөв, гүйцэтгэлийг хэмжих чанарын болон тоон шалгуур үзүүлэлт, хүрэх үр дүнг нарийвчлан баталдаггүй, санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийг төсвийн бусад байгууллагуудын нэгэн адил сар тутам гаргадаггүйгээс мэдээлдэггүй байна. Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-д заасан төсөл, хөтөлбөр, 3.1.2-т заасан ТӨҮГ харьяалах дээд байгууллага нь ТӨҮГ, төсөл хөтөлбөрийн төсөв, шалгуур үзүүлэлт, хүрэх үр дүнг дэлгэрэнгүйгээр батлах, түүнийг мэдээлэх эрх зүйн зохицуулалтыг бий болгох;

2. Банкны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2-т заасан Банк, түүний хараат болон охин компанид хориглох үйл ажиллагаатай нийцэхгүй, Байгууллагын нууцын тухай хууль, Хувь хүний нууцын тухай хуультай зөрчилдөх, бизнесийн өрсөлдөөнд сөргөөр нөлөөлөх нөхцөл байдал үүсгэж байна. Хуулиар тусгайлсан зохицуулалттай байгууллагуудын мэдээлэх мэдээллийн агуулга, стандартыг Төрийн нууцын жагсаалт батлах тухай хууль, Банкны тухай хууль, Байгууллагын нууцын тухай хууль, Хувь хүний нууцын тухай хуультай нийцүүлэн шинэчилж, шилэн дансны цахим санд байршуулах эрх зүйн орчныг боловсронгуй болгох;

3. Салбарын хуулийн дагуу ажилтнуудад олгож буй нэг удаагийн урамшууллыг мэдээлэх асуудлыг хувь хүний нууцын тухай хуультай нийцүүлэн шинэчлэн боловсруулах;

4. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг нэг мөр болгон жигдрүүлж эрчимжүүлэх зорилгоор дор дурдсан асуудлаар хууль санаачилж УИХ-д өргөн барьж шийдвэрлүүлэх. Үүнд:

- Улсын бүртгэлийн ерөнхий хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулиудын төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжийн бүртгэлтэй холбоотой зүйл, заалтуудыг уялдуулан боловсронгуй болгож тэдгээрийн бүртгэл, мэдээллийн нэгдмэл байдлыг хангах,

- Жил бүрийн 12 сард дараа жилд Шилэн дансны тухай хуулийг дагаж мөрдөх субъектийн жагсаалтыг хуулийн 3 дугаар зүйлд заасан ангиллаар гаргаж батлах, уг жагсаалтад ороогүй байгууллагуудад тухайн жилд төсөв, хөрөнгө хуваарилахгүй байх хууль эрх зүйн зохицуулалт бий болгох;

- Хуулийн 3 дугаар зүйлд заасан байгууллагууд мөнгөн дүнгийн хэмжээнээс үл хамааран бүх гүйлгээг шилэн дансаар мэдээлдэг болгох;

-Хууль дагаж мөрдөх, хэрэгжүүлэх үүрэг бүхий албан тушаалтан, байгууллагуудын гаргасан зөрчил, түүнд ногдох хариуцлагын тогтолцоог хуульд тодорхой болгож тусгах;

ҮАГ- НАГ/2016/ 04-НА кодтой аудитаар өгсөн зөвлөмж:

Хууль, тогтоомж, гэрээний үндсэн дээр төрийн чиг үүргийг хэрэгжүүлж байгаа байгууллагуудыг шилэн дансны цахим хуудсанд бүртгүүлэх ажлыг хэрэгжүүлж байгаа боловч хуулийн энэхүү ангиллын нарийвчилсан тодорхойлолт, тэдгээрийг бүртгэх нэгдсэн тогтолцоо байхгүй зэргээс шалтгаалан шилэн дансны нэгдсэн бүртгэлд бүрэн хамруулж чадаагүй байна.

Төрийн чиг үүрэгт хамаарах ажил үйлчилгээг гэрээний үндсэн дээр гүйцэтгэгч байгууллага болон улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр ажил, үйлчилгээ үзүүлж буй ААНБ-ын тодорхойлолт, эрх, үүрэг, тэдгээрийг шилэн дансанд бүртгэх, мэдээлэл оруулах, хасах нөхцөл, шаардлагыг журмаар нарийвчлан зохицуулах;

ҮАГ- НАГ/2017/0 3-НА кодтой аудитаар өгсөн зөвлөмж:

1. Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.8.1, 6.8.2, 6.8.3-т хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3-т заасан ТӨҮГ “төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах аливаа шийдвэр”-ийг мэдээлэхээр заагаагүй байхад “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга нийтлэг стандартыг тогтоох журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.2.3 - т мэдээлэхээр зааж, хуульд заагаагүй үүрэг хүлээлгэн мэдээлүүлж байгаа нь төр, орон нутгийн өмчийн оролцоотой компанийн зах зээлд давуу байдлаа хамгаалахад сөргөөр нөлөөлөх нөхцөлийг бүрдүүлсэн байна.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-т төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, 3.1.2-т төрийн өмчит үйлдвэрийн газар хуулийн үйлчлэлд хамаарахаар давхардуулсан, мөн хуулийн 8 дугаар зүйлийн 8.2-т ТЭЗ-ийн дотоод хяналтыг зөвхөн энэ хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-т заасан байгууллагад хуульчилсан нь Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1, 69.3-т нийцэхгүй байна.

Иймд Шилэн дансны тухай хуулийг Төсвийн тухай хуульд нийцүүлэх, тайланд дурдагдсан хуульчлах шаардлагатай асуудлуудыг судалж шийдвэрлэх.

2. Шилэн дансанд мэдээлэл тавихтай холбогдсон харилцааг зохицуулж байгаа “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга нийтлэг стандартыг тогтоох журам” нь Захиргааны ерөнхий хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.2, 60.1.8-д заасан захиргааны хэм хэмжээний актын шаардлагад нийцээгүй байна.

Хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4, 6.5-д заасан заалтыг давхардуулан зохицуулсан;

Хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.3-т тендерийн урилгыг мэдээлэхээр заасан байхад журамд нарийвчилсан зохицуулалт тусгаагүй, нэгдсэн цахим хуудаст мэдээлэх цонх байхгүй байна.

Иймд Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ыг Шилэн дансны тухай хууль болон Захиргааны ерөнхий хуульд

нийцүүлэх, тайланд дурдагдсан журамлах шаардлагатай асуудлыг судалж шийдвэрлэх.

3. Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээ, ажил, үйлчилгээ гүйцэтгэж байгаа аж ахуй нэгж, байгууллага болон төрийн чиг үүрэгт хамаарах ажил үйлчилгээг гэрээний үндсэн дээр гүйцэтгэгчийн мэдээлэх үүргийн хэрэгжилтэд хяналт тавих байгууллага, албан тушаалтан, хүлээлгэх хариуцлагыг хуульд тодорхой тусгаагүйгээс дээрх байгууллагууд нэгдсэн цахим хуудаст бүрэн хамрагдахгүй байна.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4, 3.1.5-д заасан аж ахуй нэгж, байгууллагуудтай байгуулах гэрээнд шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд хуульд заасан мэдээллийг байршуулах үүргийг тусгаж, биелэлтээр санхүүжилт олгох арга хэмжээ авах.

ҮАГ- НАГ/2018 /01-НА кодтой аудитаар өгсөн зөвлөмж:

1. Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-д хамаарах Хүмүүнлэгийн болон буцалтгүй тусламж, хөнгөлөлттэй зээл хэлбэрээр санхүүждэг зарим томоохон төсөл, хөтөлбөрүүдийн хувьд санхүүжүүлэгч байгууллагаас гүйцэтгэгч хуулийн этгээдэд зарим санхүүжилтийг шууд шилжүүлдгээс тухайн төсөл, хөтөлбөрийн төсвийн зарцуулалт, гүйцэтгэлийн мэдээлэл бүрэн мэдээлэгдэхгүй байгаа нь хуулийн 4 дүгээр зүйлд заасан “мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх” зарчим хангагдахгүй байна.

Хүмүүнлэгийн болон буцалтгүй тусламж, хөнгөлөлттэй зээл хэлбэрээр санхүүждэг зарим томоохон төсөл, хөтөлбөр болон Засгийн газрын тусгай сангийн төсөв зарцуулах үйл ажиллагааг ил тод мэдээлэх талаар хууль, эрх зүйн орчныг сайжруулах шаардлагатай байна.

2. Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.2.3-т Засгийн газрын тусгай сангийн “төсөв санхүүгийн үйл ажиллагааны төлөвлөлт, гүйцэтгэл, хэрэгжилт, тайлагнал, эдгээртэй холбоотой мөнгөн болон бусад гүйлгээ” хуулийн үйлчлэлд хамаарах ерөнхий зохицуулалтыг тусгасан. Иймд Засгийн газрын тусгай сангийн төсвөөс зээл, хөнгөлөлт, урамшуулал олгох сонгон шалгаруулалтын үйл ажиллагааг ил тод мэдээлэх зохицуулалтыг холбогдох хууль тогтоомжтой уялдуулан Шилэн дансны тухай хууль, журамд нэмж тусгах шаардлагатай.

Мөн тайланд зөрчилтэй асуудлыг дурдсан Засгийн газрын тусгай сангуудын төсөв санхүүгийн үйл ажиллагааг ил тод мэдээлэх зохицуулалтыг Шилэн дансны тухай хуультай уялдуулах талаар холбогдох арга хэмжээ авах;

3. Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4, 3.1.5-д хамаарах арван сая төгрөгөөс дээш үнийн дүнгээр улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөр, арга хэмжээ, ажил, үйлчилгээ гүйцэтгэгч ААНБ-ууд Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст бүрэн хамрагдаагүй, төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг гүйцэтгэгчид хуульд заасан мэдээллийг мэдээлээгүй нь санхүүжилт олгосон байгууллагаас хяналт тавих, хариуцлага хүлээлгэх зохицуулалтгүйтэй холбоотой тул уг асуудлыг хууль, журамд нэмж зохицуулах шаардлагатай байна.

Иймд Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3, 3.1.4, 3.1.5-д хамаарах хуулийн этгээдийн шилэн дансны үйл ажиллагаанд хяналт тавих этгээдийг оновчтой

тодорхойлж, хүлээлгэх хариуцлагыг Шилэн дансны тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомжтой уялдуулах талаар арга хэмжээ авах зэрэг болно.

4. Шилэн дансны нэгдсэн цахим хуудасны боловсруулалт, хөгжүүлэлт хангалтгүйгээс www.tender.gov.mn сайтад мэдээллийг давхардуулж байршуулдаг, мэдээлэл байршуулах цэс бусад төсөв, санхүүгийн төлөвлөх, тайлагнах загвар маягтуудтай уялдаагүйгээс мэдээллийг гараар шивж оруулдаг зэргээр ажлын хэт ачаалал үүсгэдэг, байгууллагуудын хөтөлж байгаа цэс нь зөрүүтэй үүсгэгдсэн зэрэг зөрчилтэйгөөс хуулийн 4 дүгээр зүйлд заасан “мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх, мэдээлэл ач холбогдолтой байх” зарчмын хэрэгжилт хангалтгүй байна.

Шилэн дансны нэгдсэн цахим хуудсыг эрхлэн хөтлөх чиг үүргийн хүрээнд цахим хуудасны агуулга стандартыг хууль, журамд нийцүүлэн, хуулийн үйлчлэлд хамаарах байгууллагуудын төсөв, санхүү, худалдан авах ажиллагаанд ашигладаг бусад систем, программтай уялдуулан мэдээллийг шууд хөрвүүлж хялбаршуулсан байдлаар ил тод мэдээлэхээр шинэчлэн хөгжүүлэх арга хэмжээ авах;

Хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д заасны дагуу баг, хороодын иргэдийн Нийтийн Хурлын хяналтын чиг үүргийг хэрэгжүүлэх арга зүйг боловсронгуй болгож, холбогдох сургалт зохион байгуулах;

УАГ- НАГ/2019 /01-НА кодтой аудитаар өгсөн зөвлөмж:

1. Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1 -д заасны дагуу Хөдөлмөрийн гэрээ, контракт байгуулан ажилладаг төрийн үйлчилгээний албан хаагчид Шилэн дансны тухай хуулийн дагуу холбогдох мэдээллийг байршуулах үүрэг хүлээсэн байдаг.

Гэтэл тус хуулийн 10 дугаар зүйлийн 10.1-т “Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ” гэж зааснаас Хөдөлмөрийн гэрээ, контрактаар ажилладаг төрийн үйлчилгээний албан хаагчид Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж ажиллагаагүй тохиолдолд дээрх заалтын дагуу хариуцлага тооцох эрх зүйн зохицуулалтыг орхигдуулжээ.

Монгол Улсын Ерөнхий сайдын 2018 оны 154 дүгээр захирамжаар байгуулсан Шилэн дансны тухай хууль болон бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсгийн ажлыг эрчимжүүлэх;

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн байдалд 2015-2019 онуудад хийгдсэн нийцлийн аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн дагуу тус хууль болон Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудаас тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-д нэмэлт, өөрчлөлт оруулах арга хэмжээ авч ажиллах.

2. ШДНЦХ-ны боловсруулалт, хөгжүүлэлт хангалтгүйгээс дараахь зөрчил, хүндрэлийг үүсгэж хуулийн 4 дүгээр зүйлд заасан “мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх, мэдээлэл ач холбогдолтой байх” зарчим хэрэгжихгүйд хүргэжээ. Үүнд:

- Улс орон нутгийн бүх ТЕЗ болон түүний шууд харьяаны байгууллага нь ШДНЦХ-т тус бүрдээ мэдээлэл байршуулах цэс үүсгэснээс 1 ТЕЗ- ийн төсөв

- зарцуулах үйл ажиллагааг 2 газарт давхар мэдээлэх хүндрэлийг үүсгэж ажлын ачаалал нэмсэн;
- ШДНЦХ-т тендерийн урилга байршуулах цэс үүсгээгүй орхигдуулсан;
 - Хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт төрийн байгууллага, төрийн болон төрийн өмчит хуулийн этгээдүүд 6 төрлийн мэдээллийг хуульд заасан хугацаанд жилд 26 удаа мэдээлэхээр тусгасан байхад ШДНЦХ-т 8-10 төрлийн мэдээллийг жилд 64-ээс дээш удаа мэдээлэх цэс үүсгэж ажлын ачаалал нэмсэн;
 - Хуулийн 6 дугаар зүйлийн 6.4 дэх хэсэгт төрийн байгууллага, төрийн болон төрийн өмчит хуулийн этгээдүүд 9 төрлийн мэдээллийг шийдвэр гарснаас хойш тухай бүр 7 хоногийн дотор мэдээлэхээр заасан байхад ШДНЦХ-т 10 төрлийн мэдээллийг жилд 64 удаа, 8 төрлийн мэдээллийг тухай бүр 7 хоногийн дотор мэдээлэх цэс үүсгэж ажлын ачаалал нэмсэн;
 - Байгууллагууд 10 сая төгрөгөөс дээш худалдан авах ажиллагаатай холбоотой мэдээллийг ШДНЦХ болон www.tender.gov.mn хаягаар давхар мэдээлдгээс ажлын ачаалал үүсгэж, мэдээлэл дутуу байршуулдаг.

Сангийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2018 оны А/210 дугаар тушаалаар байгуулсан дэд Ажлын хэсгийн ажлыг эрчимжүүлэх;

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн байдалд 2015-2019 онуудад хийгдсэн нийцлийн аудитын тайлан, дүгнэлтийн дагуу тус хууль болон Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудаст тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-д нэмэлт, өөрчлөлт оруулах арга хэмжээ авч ажиллах;

Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст мэдээлэл байршуулах ажлыг хялбаршуулж, цахим хуудсыг хөгжүүлэх арга хэмжээ авч ажиллах.

ҮАГ-НАГ/2020/01-НА кодтой аудитаар өгсөн дүгнэлт, зөвлөмж:

1. Хуулийн үйлчлэлд хамаарах байгууллага, албан тушаалтнууд ил тод байршуулах нийт мэдээллийн 14.3 хувийг хуульд заасан хугацаа хоцроосон зөрчилтэй байгаагаас үзэхэд тухайн зөрчлийг гаргахгүй байх хяналт, хариуцлагын тогтолцоог сайжруулах шаардлагатайг харуулж байна.

2. Улс, орон нутгийн төсвөөс санхүүжилт авсан ААНБ-д хяналт тавих, хариуцлага тооцох эрх зүйн тогтолцоог хууль, журамд тусгах, ШДНЦХ-т мэдээлэл байршуулах, хяналт тавих үйл ажиллагааг мэдээллийн технологи, программ хангамж ашиглан хялбарчлах ажлыг эрчимжүүлэх шаардлагатай байна.

3. Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4-д заасан аж ахуйн нэгж, байгууллагын мэдээлэх үүргийн хэрэгжилтэд хяналт тавих байгууллага, албан тушаалтанд хүлээлгэх хариуцлагын талаар эрх зүйн зохицуулалтгүйгээс хөрөнгө оруулалт, ОНХС-ийн төсөл, арга хэмжээг гүйцэтгэгч ААНБ-ууд ШДНЦХ-т хамрагдалт дунджаар 10.0%-тай байгаа нь хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнд иргэд, олон нийт хяналт тавих, холбогдох мэдээлэл авах боломжгүй байна.

4. Иргэд, олон нийт ШДНЦХ-т байршуулсан мэдээлэлтэй танилцаж, мэдээлэл авдаг байдал өссөн үзүүлэлттэй байна.

5.Нийслэл болон зарим аймгийн ТЕЗ-ийн дотоод хяналт, шалгалтыг хангалтгүй хэрэгжүүлж байгаа нь Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд холбогдох хяналтыг хэрэгжүүлэх давтамж, хугацаа болон хяналтын чиг үүргээ бүрэн хэрэгжүүлээгүй албан тушаалтанд хариуцлага тооцох эрх зүйн зохицуулалтгүйтэй холбоотой байна.

6.ШДНЦХ-т мэдээлэл оруулах арга зүйг боловсронгуй болгож, эрх зүйн орчныг сайжруулах чиглэлээр төрийн аудитын байгууллагаас өмнөх жилүүдэд өгсөн аудитын зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүйгээс зарим зөрчил давтан гарсаар байна.

Мөн түүнчлэн Шилэн дансны тухай хууль хэрэгжиж эхэлснээс хойш Үндэсний Аудитын Газраас жил бүр 1-2 удаа нийцлийн аудит хийж байна. Түүнчлэн Нээлттэй нийгэм форумаас 2019 онд 582 иргэн хамарсан “ШДНЦХ-ны хэрэглэгчийн санал асуулгын судалгаа”-г хэрэгжүүлсэн.

Монгол Улсын Ерөнхий сайдын 2018 оны 9 дүгээр сарын 11-ний өдрийн 154 дүгээр захирамжаар Шилэн дансны тухай хуулийг бусад хууль тогтоомжид нийцүүлэх, нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөл боловсруулах ажлын хэсгийг байгуулсан бөгөөд Сангийн яамны Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар дэд ажлын хэсэг байгуулж, Европын холбооны буцалтгүй тусламжийн санхүүжилтээр Дэлхийн банктай хамтран хэрэгжүүлж буй “Монгол улсад засаглалыг бэхжүүлэх төсөл”-ийн хүрээнд Шилэн дансны эрх зүйн орчин, ШДНЦХ-ыг боловсронгуй болгох чиглэлээр зөвлөх үйлчилгээ авч ажиллуулсан.

Зөвлөх үйлчилгээний хүрээнд “Шилэн дансны хууль, журмын хэрэгжилт, системийн ашиглалтын өнөөгийн байдал, тулгарч буй хүндрэл бэрхшээл, сайжруулах арга замыг тодорхойлох” зорилго бүхий судалгааг хийж, уг судалгаанд шилэн дансны нэгдсэн цахим хуудаст мэдээлэл оруулагч этгээд, мэдээлэл хэрэглэгч этгээд болон мэргэжлийн холбоод, их дээд сургууль, иргэдийн төлөөлөл, хяналт тавьдаг эрх бүхий этгээд, Сангийн яамны холбогдох газар, хэлтсийн төлөөллөөс 2020 оны 2 дугаар сарын 19-ний өдрөөс 4 дүгээр сарын 03 хүртэл нийт 1,645 оролцогчийг хамруулан зохион байгуулсан.

Дээрх дурдагдсан тоон болон баримтын судалгаа, аудитын тайлан зэргээс дүгнэн үзвэл Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлалын 3.2.2-т заасан “нийгмийн харилцааны өөрчлөлт, хөгжлөөс хоцорсон, зайлшгүй зохицуулах ёстой харилцааг хамарч зохицуулаагүй, эсхүл тэдгээрээс улбаалсан сөрөг үр дагавар бий болсон” гэх, 3.2.3-т заасан “захиргааны байгууллага эрх хэмжээнийхээ хүрээнд хууль тогтоомжийг хэрэгжүүлэх явцад хүндрэл бэрхшээл үүссэн”, 3.2.4-т нийгмийн бүлэг, төрийн бус байгууллага хуулийн хэрэгжилттэй холбоотой тодорхой асуудлаар түүнийг өөрчлөх, шинэчлэх, эсхүл хүчингүй болгох талаар үндэслэл бүхий санал гаргасан,” гэх, 3.2.5-д заасан “төрөөс хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, хангах талаарх үүргээ биелүүлэхгүй байгаа” гэх мэт хуулийн хэрэгжилтийн шалтгаан үндэслэл бий болсон гэж тодорхойлохоор байна.

1.2.Үнэлгээ хийх хүрээ

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний хүрээг тогтоох ажиллагааг “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”-ын 3.3-т заасны дагуу хийх бөгөөд хуулийн хэрэгжилтийн үр дагаврыг судлах явцад илэрсэн зөрчилдөөнтэй, хэрэгжилтийн явцад сөрөг үр дагавар бий болсон, хэрэгжүүлэхэд хүндрэл бэрхшээл үүсгэж буй, хуулийн зорилтыг хангах үүргээ биелүүлэхгүй байгаа зохицуулалтыг агуулгын хувьд тодорхойлохыг зорьсон болно.

Хуулийн зохицуулалтыг тус бүрээр нь ангилсан байдлаар дараахь хүснэгтээр үнэлгээ хийх хүрээг хуулийн зүйл, хэсэг, заалт тус бүрээр тогтоов.

Хүснэгт-1

№	Үнэлгээ хийх зүйл	Хэсэг, заалт
1.	3 дугаар зүйл. Хуулийн үйлчлэх хүрээ	3.1.Доор дурдсан байгууллага, түүний эд хөрөнгө захиран зарцуулах эрх бүхий албан тушаалтан энэ хуулийн үйлчлэлд хамаарна: 3.1.1.төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд; 3.1.2.төрийн өмчит үйлдвэрийн газар; 3.1.3.хяналтын багц буюу түүнээс дээш хэмжээний хувьцааг нь төр, орон нутаг болон тэдгээрийн нэгдмэл сонирхолтой этгээд эзэмшиж байгаа компани; 3.1.4.улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөр, арга хэмжээ, ажил, үйлчилгээ гүйцэтгэж байгаа аж ахуйн нэгж, байгууллага; 3.1.5.төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг хууль тогтоомж, гэрээний үндсэн дээр гүйцэтгэгч. 3.2.Энэ хуульд дараах төсөв, санхүүгийн үйл ажиллагааны төлөвлөлт, гүйцэтгэл, хэрэгжилт, тайлагнал эдгээртэй холбоотой мөнгөн болон бусад гүйлгээ хамаарна: 3.2.1.улс, орон нутгийн төсөв болон Нийгмийн даатгалын сангийн төсөв; 3.2.3.Засгийн газрын тусгай сан; 3.2.5.Засгийн газар, орон нутгийн өрийн бичиг, санхүүгийн бусад хэрэгсэл; 3.2.8.Засгийн газар, орон нутгийн баталгаа болон төсвийн өр, авлага үүсгэх аливаа бусад шийдвэр. 3.4.Төрийн нууцад хамаарахаас бусад төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, хэрэгжилт, тайлагналыг байгууллагын нууцад хамааруулан нийтэд мэдээлэхээс зайлсхийхийг хориглоно.
2.	6 дугаар зүйл. Шилэн дансны мэдээлэл	6.1.Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ: 6.1.1.тухайн жилийн төсөв, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлтийг жил бүрийн 01 дүгээр сарын 10-ны өдрийн дотор;

		6.1.2.хагас жилийн төсвийн гүйцэтгэлийг жил бүрийн 08 дугаар сарын 15-ны өдрийн дотор, өмнөх оны төсвийн гүйцэтгэлийг жил бүрийн 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор, сар, улирлын гүйцэтгэлийг дараа сарын 08-ны өдрийн дотор; 6.1.3.дараа жилийн төсвийн төслийг жил бүрийн 09 дүгээр сарын 15-ны өдрийн дотор; 6.1.4.жилийн эцсийн санхүүгийн тайланг дараа жилийн 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор, хагас жилийн тайланг 08 дугаар сарын 15-ны өдрийн дотор; 6.1.5.төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн багцад хийсэн аудитын дүгнэлтийг бүрэн эхээр нь тухайн жилийн 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор, аудитын тайлан, дүгнэлтэд тусгагдсан асуудлаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээг тухайн жилийн 07 дугаар сарын 01-ний өдрийн дотор; 6.1.6.төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбарыг улирал бүр.
		6.2.Энэ хуулийн 6.1.1-д заасан мэдээлэл дараах байдлаар илэрхийлэгдсэн байна: 6.2.1.эрх бүхий байгууллагаас баталсан жилийн төсөв, гүйцэтгэлийг хэмжих шалгуур үзүүлэлт; 6.2.2.орлого /үндсэн үйл ажиллагааны орлого, төсөвт байгууллагын өөрийн орлого/; 6.2.3.урсгал зардал /цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэл, бусад урсгал зардал, хөрөнгийн зардал, татаас шилжүүлэг/; 6.2.4.хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, концессын зүйлийн жагсаалт; 6.2.5.улсын төсөв болон орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлого, тэдгээрийн задаргаа; 6.2.6.зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр /улсын төсөв, орон нутгийн төсөв, өөрийн орлого/.
		6.3.Энэ хуулийн 6.1.2-т заасан мэдээлэл дараах байдлаар илэрхийлэгдсэн байна: 6.3.1.Төсвийн ерөнхийлөн захирагчийн энэ хуулийн 6.2.1-д тодорхойлсон үзүүлэлт, хүрсэн үр дүн, хэрэгжилтийг хэмжих тоон болон чанарын үзүүлэлт; 6.3.2.төсвийн гүйцэтгэлийг батлагдсан төсвийн төлөвлөгөөтэй харьцуулсан харьцуулалт; 6.3.3.төсөв хэмнэсэн болон хэтэрсэн бол холбогдох шалтгааныг тайлбарласан тайлбар; 6.3.4.өмнөх оны төсвийн зарлагын хэмнэлт, туслах үйл ажиллагааны орлогын давсан хэсгийг урамшуулалд зарцуулсан бол зориулалтыг заасан байх; 6.3.5.хандив, тусламжийн хэмжээ, түүний зарцуулалт;

		6.3.6.хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээг тендер зарлаж, сонгон шалгаруулсан бол шалгаруулалтын ерөнхий мэдээлэл; 6.3.7.хөрөнгө оруулалтын зарлага, санхүүжилтийг төсөл, объект тус бүрээр; 6.3.8.тусгай сангийн орлого, зарлага, хөрөнгө оруулалт; 6.3.9.орон нутгийн хөгжлийн сангийн гүйцэтгэл. 6.4.Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ: 6.4.1.тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт; 6.4.2.тухайн байгууллагын хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээнд орсон өөрчлөлт; 6.4.3.тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилга, тендерт оролцохыг сонирхогчид тавих шалгуур үзүүлэлт, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгаан; 6.4.4.таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг; 6.4.5.цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр; 6.4.6.худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт шалгалтын дүн; 6.4.7.байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлт; 6.4.8.бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс,төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр; 6.4.9.хууль тогтоомжид заасан бусад мэдээлэл. 6.5.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага энэ хуулийн 6.1, 6.4-т заасан мэдээллээс гадна дараах мэдээллийг гаргана: 6.5.1.улсын төсөв, Нийгмийн даатгалын сангийн төсвийн орлого, зарлага, хөрөнгө оруулалт, төсвийн нэгдсэн үзүүлэлтийг хагас жилийн байдлаар тухайн жилийн 07 дугаар сарын 15-ны өдрийн дотор, жилийн эцсийн байдлаар дараа жилийн 01 дүгээр сарын 15-ны өдрийн дотор;
--	--	---

		6.5.2.Засгийн газрын гадаад зээл, тусламжийн ашиглалтын мэдээг улирал бүр; 3.4.Төрийн нууцад хамаарахаас бусад төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, хэрэгжилт, тайлагналыг байгууллагын нууцад хамааруулан нийтэд мэдээлэхээс зайлсхийхийг хориглоно. 6.5.3.Засгийн газрын гадаад, дотоод өрийн мэдээллийг улирал бүр; 6.5.4.улсын төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбарыг улирал бүр; 6.5.5.нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээг сар бүрийн 15-ны өдрийн дотор; 6.5.6.төсвийн гүйцэтгэл болон аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайланг дараа жилийн 08 дугаар сарын 25-ны өдрийн дотор; 6.5.7.төсвийн алдагдлыг санхүүжүүлэх зорилгоор гаргасан Засгийн газрын дотоод үнэт цаасны мэдээллийг улирал бүр. 6.5.8.концессын зүйлийн жагсаалт болон түүнд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг батлагдсанаас нь хойш долоо хоногийн дотор; 6.5.9.концессын гэрээ болон түүнд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг гэрээ байгуулагдсанаас нь хойш долоо хоногийн дотор; 6.5.10.концессын гэрээ байгуулсан тухай бүрд концесс эзэмшигч, түүний байгууллагын нууцад хамаарахаас бусад мэдээлэл, концессын зүйл, гүйцэтгэх ажил, үзүүлэх үйлчилгээний талаарх мэдээллийг долоо хоногийн дотор; 6.5.11.хөрөнгө оруулалтыг санхүүжүүлэх зорилгоор гаргасан Засгийн газрын гадаад үнэт цаасны мэдээллийг улирал бүр; 6.5.12.улсын төсвийн нэгдсэн үзүүлэлтийг макро эдийн засгийн үзүүлэлт, холбогдох бусад үзүүлэлттэй уялдуулсан судалгаа, тооцоог улирал бүр. 6.8.Энэ хуулийн 3.1.3-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ: 6.8.1.тухайн байгууллагад холбогдох энэ хуулийн 3.2.5, 3.2.7, 3.2.8-д заасан шийдвэр; 6.8.2.худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилга, тендерт оролцохыг сонирхогчдод тавих шалгуур үзүүлэлт, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгаан; 6.8.3.төр болон орон нутаг тавь буюу түүнээс дээш хувийг эзэмшиж байгаа компанийн гаргасан их хэмжээний хэлцэлд тооцогдохуйц баталгаа, батлан даалт. 6.9.Арван сая төгрөгөөс дээш үнийн дүнгээр улс, орон нутгийн төсөв, Засгийн газрын болон орон нутгийн тусгай
--	--	---

		зориулалтын сан, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалт, санхүүжилт, Засгийн газар, түүний харьяа байгууллагаас гаргасан бонд, үнэт цаас, өрийн бичиг, баталгаа, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээний дагуу хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөр, арга хэмжээний дагуу санхүүжиж байгаа энэ хуулийн 3.1.4, 3.1.5-д заасан этгээд нь нийт төсөвт өртөг, хэрэгжилтийн явц, үе шат, зарлага, санхүүжилтийн мэдээллийг Засгийн газраас тогтоосон журмын дагуу улирал бүр хөрөнгө оруулалт, санхүүжилтээ хүлээн авсан төсвийн байгууллагын цахим хуудас, мэдээллийн самбар, шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд байрлуулах ба шаардлагатай гэж үзвэл олон нийтийн бусад цахим хуудас, өөрийн цахим хуудсаар давхар мэдээлж болно. Мэдээллийг төсвийн байгууллагын цахим хуудас, мэдээллийн самбар, шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд байрлуулахад энэ хуулийн 3.1.4, 3.1.5-д заасан этгээд төлбөр төлөхгүй. 6.10.Шилэн дансны мэдээлэл, зарлагын гүйлгээ бүрд түүнд холбогдох эрх бүхий этгээдийн шийдвэрийн эх хуулбар, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдлийг хавсаргасан байна.
3.	8 дугаар зүйл. Хуулийн хэрэгжилтэд тавих хяналт	8.2.Энэ хуулийн 3.1.1-д заасан төсвийн байгууллага, албан тушаалтны шилэн дансны үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлд заасны дагуу төсвийн ерөнхийлөн захирагч хэрэгжүүлнэ.
4.	10 дугаар зүйл. Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага	10.1.Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

1.3. Үнэлгээ хийх шалгуур үзүүлэлтийг тогтоох:

Үнэлгээ хийхээр сонгосон хуулийн дээр дурдсан зүйл, хэсэг, заалтын хэрэгжилтийн байдлыг бодитоор илэрхийлж тогтоох боломжтой үнэлгээ хийх шалгуур үзүүлэлтийг дараахь байдлаар хийхээр сонгож тогтлоо. Үүнд:

- Зорилгод хүрсэн түвшин
- Хүлээн зөвшөөрөгдсөн байдал
- Практикт нийцэж байгаа байдал

2014 оны 07 сарын 01-ний өдөр батлагдсан Шилэн дансны тухай хуулийн зохицуулалтууд нь уг хуулийн 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсэгт заасан “улс, орон нутгийн төсөв, улсын болон орон нутгийн өмчийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах зорилгоор төсвийн удирдлагыг хэрэгжүүлэх шийдвэр, үйл ажиллагаа ил тод, нээлттэй, ойлгомжтой байх, түүнд олон нийт хяналт тавих мэдээллийн тогтолцоог бүрдүүлэх” гэж заасан зорилтыг бүрэн хангаж байгаа эсэхийг зорилгод

хүрсэн түвшин шалгуур үзүүлэлтээр тодорхойлохоос гадна хуулийн зүйл, заалт, хэсэг нь тухайн хэм хэмжээний зохицуулалтын зорилгыг хангаж байгааг тодорхойлно.

Иргэн, хуулийн этгээд, төрийн албан тушаалтнаас Шилэн дансны тухай хуулийг хэрэгжиж байгаа байдал болон эрх зүйн үр дагаврыг хэрхэн хүлээн авч байгаа болон сайн дураараа биелүүлж байгаа эсэхийг тус тус хүлээн зөвшөөрөгдөх байдал шалгуур үзүүлэлтээр тодорхойлно. Энэ нь уг хуулийн үр нөлөөг шууд хүртэж буй иргэн, хуулийн этгээд болон хуулийг биелүүлж хэрэгжүүлж байгаа болон хяналт тавьж байгаа байгууллага, албан тушаалтнуудын санал, шүүмжлэл, хяналт шалгалтын үр дүнг илэрхийлэх нэг үзүүлэлт болно.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт, түүний эерэг болон сөрөг үр дагавар, хуулийг хэрэгжүүлэхэд гарч буй хүндрэл, бэрхшээл, хуулийн зохицуулалтын хийдэл байгаа эсэхийг практикт нийцэж байгаа шалгуур үзүүлэлтээр тодорхойлно.

Хүснэгт-2:

№	Үнэлгээ хийх зүйл	Хэсэг, заалт	Шалгуур үзүүлэлт
1.	3 дугаар зүйл. Хуулийн үйлчлэх хүрээ	3.1.Доор дурдсан байгууллага, түүний эд хөрөнгө захиран зарцуулах эрх бүхий албан тушаалтан энэ хуулийн үйлчлэлд хамаарна: 3.1.1.төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд; 3.1.2.төрийн өмчит үйлдвэрийн газар; 3.1.3.хяналтын багц буюу түүнээс дээш хэмжээний хувьцааг нь төр, орон нутаг болон тэдгээрийн нэгдмэл сонирхолтой этгээд эзэмшиж байгаа компани; 3.1.4.улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөр, арга хэмжээ, ажил, үйлчилгээ гүйцэтгэж байгаа аж ахуйн нэгж, байгууллага; 3.1.5.төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг хууль тогтоомж, гэрээний үндсэн дээр гүйцэтгэгч. 3.2.Энэ хуульд дараах төсөв, санхүүгийн үйл ажиллагааны төлөвлөлт, гүйцэтгэл, хэрэгжилт, тайлагнал эдгээртэй холбоотой мөнгөн болон бусад гүйлгээ хамаарна: 3.2.1.улс, орон нутгийн төсөв болон Нийгмийн даатгалын сангийн төсөв; 3.2.3.Засгийн газрын тусгай сан;	Практикт нийцэж байгаа байдал Хүлээн зөвшөөрөгдсөн байдал

		3.2.5.Засгийн газар, орон нутгийн өрийн бичиг, санхүүгийн бусад хэрэгсэл; 3.2.8.Засгийн газар, орон нутгийн баталгаа болон төсвийн өр, авлага үүсгэх аливаа бусад шийдвэр. 3.4.Төрийн нууцад хамаарахаас бусад төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, хэрэгжилт, тайлагналыг байгууллагын нууцад хамааруулан нийтэд мэдээлэхээс зайлсхийхийг хориглоно.	
2.	6 дугаар зүйл. Шилэн дансны мэдээлэл	6.1.Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ: 6.1.1.тухайн жилийн төсөв, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлтийг жил бүрийн 01 дүгээр сарын 10-ны өдрийн дотор; 6.1.2.хагас жилийн төсвийн гүйцэтгэлийг жил бүрийн 08 дугаар сарын 15-ны өдрийн дотор, өмнөх оны төсвийн гүйцэтгэлийг жил бүрийн 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор, сар, улирлын гүйцэтгэлийг дараа сарын 08-ны өдрийн дотор; 6.1.3.дараа жилийн төсвийн төслийг жил бүрийн 09 дүгээр сарын 15-ны өдрийн дотор; 6.1.4.жилийн эцсийн санхүүгийн тайланг дараа жилийн 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор, хагас жилийн тайланг 08 дугаар сарын 15-ны өдрийн дотор; 6.1.5.төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн багцад хийсэн аудитын дүгнэлтийг бүрэн эхээр нь тухайн жилийн 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор, аудитын тайлан, дүгнэлтэд тусгагдсан асуудлаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээг тухайн жилийн 07 дугаар сарын 01-ний өдрийн дотор; 6.1.6.төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбарыг улирал бүр.	Практикт нийцэж байгаа байдал Хүлээн зөвшөөрөгдсөн байдал
		6.2.Энэ хуулийн 6.1.1-д заасан мэдээлэл дараах байдлаар илэрхийлэгдсэн байна: 6.2.1.эрх бүхий байгууллагаас баталсан жилийн төсөв, гүйцэтгэлийг хэмжих шалгуур үзүүлэлт; 6.2.2.орлого /үндсэн үйл ажиллагааны орлого, төсөвт байгууллагын өөрийн орлого/;	Практикт нийцэж байгаа байдал

	6.2.3.урсгал зардал /цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэл, бусад урсгал зардал, хөрөнгийн зардал, татаас шилжүүлэг/; 6.2.4.хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, концессын зүйлийн жагсаалт; 6.2.5.улсын төсөв болон орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлого, тэдгээрийн задаргаа; 6.2.6.зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр /улсын төсөв, орон нутгийн төсөв, өөрийн орлого/.	
	6.3.Энэ хуулийн 6.1.2-т заасан мэдээлэл дараах байдлаар илэрхийлэгдсэн байна: 6.3.1.Төсвийн ерөнхийлөн захирагчийн энэ хуулийн 6.2.1-д тодорхойлсон үзүүлэлт, хүрсэн үр дүн, хэрэгжилтийг хэмжих тоон болон чанарын үзүүлэлт; 6.3.2.төсвийн гүйцэтгэлийг батлагдсан төсвийн төлөвлөгөөтэй харьцуулсан харьцуулалт; 6.3.3.төсөв хэмнэсэн болон хэтэрсэн бол холбогдох шалтгааныг тайлбарласан тайлбар; 6.3.4.өмнөх оны төсвийн зарлагын хэмнэлт, туслах үйл ажиллагааны орлогын давсан хэсгийг урамшуулалд зарцуулсан бол зориулалтыг заасан байх; 6.3.5.хандив, тусламжийн хэмжээ, түүний зарцуулалт; 6.3.6.хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээг тендер зарлаж, сонгон шалгаруулсан бол шалгаруулалтын ерөнхий мэдээлэл; 6.3.7.хөрөнгө оруулалтын зарлага, санхүүжилтийг төсөл, объект тус бүрээр; 6.3.8.тусгай сангийн орлого, зарлага, хөрөнгө оруулалт; 6.3.9.орон нутгийн хөгжлийн сангийн гүйцэтгэл.	Практикт нийцэж байгаа байдал
	6.4.Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ: 6.4.1.тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт; 6.4.2.тухайн байгууллагын хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр,	Практикт нийцэж байгаа байдал

		хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээнд орсон өөрчлөлт; 6.4.3.тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилга, тендерт оролцохыг сонирхогчид тавих шалгуур үзүүлэлт, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгаан; 6.4.4.таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг; 6.4.5.цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр; 6.4.6.худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт шалгалтын дүн; 6.4.7.байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлт; 6.4.8.бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс,төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр; 6.4.9.хууль тогтоомжид заасан бусад мэдээлэл.	
		6.5.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага энэ хуулийн 6.1, 6.4-т заасан мэдээллээс гадна дараах мэдээллийг гаргана: 6.5.1.улсын төсөв, Нийгмийн даатгалын сангийн төсвийн орлого, зарлага, хөрөнгө оруулалт, төсвийн нэгдсэн үзүүлэлтийг хагас жилийн байдлаар тухайн жилийн 07 дугаар сарын 15-ны өдрийн дотор, жилийн эцсийн байдлаар дараа жилийн 01 дүгээр сарын 15-ны өдрийн дотор; 6.5.2.Засгийн газрын гадаад зээл, тусламжийн ашиглалтын мэдээг улирал бүр; 6.5.3.Засгийн газрын гадаад, дотоод өрийн мэдээллийг улирал бүр;	Хүлээн зөвшөөрөгдсөн байдал

		6.5.4.улсын төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбарыг улирал бүр; 6.5.5.нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээг сар бүрийн 15-ны өдрийн дотор; 6.5.6.төсвийн гүйцэтгэл болон аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайланг дараа жилийн 08 дугаар сарын 25-ны өдрийн дотор; 6.5.7.төсвийн алдагдлыг санхүүжүүлэх зорилгоор гаргасан Засгийн газрын дотоод үнэт цаасны мэдээллийг улирал бүр. 6.5.8.концессын зүйлийн жагсаалт болон түүнд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг батлагдсанаас нь хойш долоо хоногийн дотор; 6.5.9.концессын гэрээ болон түүнд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг гэрээ байгуулагдсанаас нь хойш долоо хоногийн дотор; 6.5.10.концессын гэрээ байгуулсан тухай бүрд концесс эзэмшигч, түүний байгууллагын нууцад хамаарахаас бусад мэдээлэл, концессын зүйл, гүйцэтгэх ажил, үзүүлэх үйлчилгээний талаарх мэдээллийг долоо хоногийн дотор; 6.5.11.хөрөнгө оруулалтыг санхүүжүүлэх зорилгоор гаргасан Засгийн газрын гадаад үнэт цаасны мэдээллийг улирал бүр; 6.5.12.улсын төсвийн нэгдсэн үзүүлэлтийг макро эдийн засгийн үзүүлэлт, холбогдох бусад үзүүлэлттэй уялдуулсан судалгаа, тооцоог улирал бүр.	
		6.8.Энэ хуулийн 3.1.3-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ: 6.8.1.тухайн байгууллагад холбогдох энэ хуулийн 3.2.5, 3.2.7, 3.2.8-д заасан шийдвэр; 6.8.2.худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилга, тендерт оролцохыг сонирхогчдод тавих шалгуур үзүүлэлт, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл,	Практикт нийцэж байгаа байдал

		шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгаан; 6.8.3.төр болон орон нутаг тавь буюу түүнээс дээш хувийг эзэмшиж байгаа компанийн гаргасан их хэмжээний хэлцэлд тооцогдохуйц баталгаа, батлан даалт.	
		6.9.Арван сая төгрөгөөс дээш үнийн дүнгээр улс, орон нутгийн төсөв, Засгийн газрын болон орон нутгийн тусгай зориулалтын сан, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалт, санхүүжилт, Засгийн газар, түүний харьяа байгууллагаас гаргасан бонд, үнэт цаас, өрийн бичиг, баталгаа, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээний дагуу хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөр, арга хэмжээний дагуу санхүүжиж байгаа энэ хуулийн 3.1.4, 3.1.5-д заасан этгээд нь нийт төсөвт өртөг, хэрэгжилтийн явц, үе шат, зарлага, санхүүжилтийн мэдээллийг Засгийн газраас тогтоосон журмын дагуу улирал бүр хөрөнгө оруулалт, санхүүжилтээ хүлээн авсан төсвийн байгууллагын цахим хуудас, мэдээллийн самбар, шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд байрлуулах ба шаардлагатай гэж үзвэл олон нийтийн бусад цахим хуудас, өөрийн цахим хуудсаар давхар мэдээлж болно. Мэдээллийг төсвийн байгууллагын цахим хуудас, мэдээллийн самбар, шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд байрлуулахад энэ хуулийн 3.1.4, 3.1.5-д заасан этгээд төлбөр төлөхгүй.	Практикт нийцэж байгаа байдал Хүлээн зөвшөөрөгдсөн байдал
		6.10.Шилэн дансны мэдээлэл, зарлагын гүйлгээ бүрд түүнд холбогдох эрх бүхий этгээдийн шийдвэрийн эх хуулбар, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдлийг хавсаргасан байна.	Практикт нийцэж байгаа байдал Хүлээн зөвшөөрөгдсөн байдал
3.	8 дугаар зүйл. Хуулийн хэрэгжилтэд тавих хяналт	8.2.Энэ хуулийн 3.1.1-д заасан төсвийн байгууллага, албан тушаалтны шилэн дансны үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлд заасны дагуу төсвийн ерөнхийлөн захирагч хэрэгжүүлнэ.	Практикт нийцэж байгаа байдал
4.	10 дугаар зүйл. Хууль зөрчигчид	10.1.Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.	Практикт нийцэж байгаа байдал

	хүлээлгэх хариуцлага		
--	-------------------------	--	--

Шалгуур үзүүлэлтийг сонгохдоо тухайн зүйл, хэсэг, заалтын хэрэгжилтийг хамгийн үр дүнтэйгээр илэрхийлэх шаардлагаар сонгосон бөгөөд тухайн хуулийн холбогдох зохицуулалтад ач холбогдолтой бус шалгуур үзүүлэлтийг сонгоогүй болно.

1.4.Харьцуулах хэлбэрийг сонгох:

Аргачлалын 3.5.1-д заасны дагуу Шилэн дансны тухай хууль хэрэгжсэнээр нийгмийн харилцаанд гарсан эерэг, сөрөг өөрчлөлтүүдийг олж тодорхойлоход харьцуулах хэлбэрүүдээс тохирохыг сонгож хэрэглэв.

Ингэхдээ хуулийн хэрэгжилтийн үр дагаврыг үнэлэх болсон шалтгаан, тогтоосон хүрээ, шалгуур үзүүлэлтээс хамааран аль болох тохиромжтой харьцуулах хэлбэрийг сонгов.

- Зорилгод хүрсэн түвшин шалгуур үзүүлэлтийг хууль тогтоомж хүчин төгөлдөр үйлчлэхээс өмнөх нөхцөл байдлыг хууль тогтоомж хүчин төгөлдөр хэрэгжсэний дараахь нөхцөл байдал буюу хууль тогтоомжийн хэрэгжилтийн явцад гарч байгаа үр дагавартай харьцуулан дүн шинжилгээ хийнэ.
- Хүлээн зөвшөөрөгдсөн байдал шалгуур үзүүлэлтийг хууль тогтоомж хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш нөхцөл байдал хэрхэн өөрчлөгдсөнийг он дарааллаар судалж тогтооно.
- Практикт нийцэж байгаа байдал шалгуур үзүүлэлтийг хууль тогтоомж хууль тогтоомж хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш нөхцөл байдал хэрхэн өөрчлөгдсөнийг он дарааллаар судалж тогтооно.

1.5.Шалгуур үзүүлэлтийг томъёолох:

Хүснэгт-3

№	Зүйл, хэсэг, заалт	Шалгуур үзүүлэлт	Шалгуур үзүүлэлтийн томъёолол
1.	3 дугаар зүйл. Хуулийн үйлчлэх хүрээ 3.1.Доор дурдсан байгууллага, түүний эд хөрөнгө захиран зарцуулах эрх бүхий албан тушаалтан энэ хуулийн үйлчлэлд хамаарна: 3.1.1.төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд; 3.1.2.төрийн өмчит үйлдвэрийн газар; 3.1.3.хяналтын багц буюу түүнээс дээш хэмжээний хувьцааг нь төр, орон нутаг болон тэдгээрийн нэгдмэл сонирхолтой этгээд эзэмшиж байгаа компани; 3.1.4.улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөр, арга хэмжээ, ажил, үйлчилгээ гүйцэтгэж байгаа аж ахуйн нэгж, байгууллага; 3.1.5.төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг хууль тогтоомж, гэрээний үндсэн дээр гүйцэтгэгч. 3.2.Энэ хуульд дараах төсөв, санхүүгийн үйл ажиллагааны төлөвлөлт, гүйцэтгэл, хэрэгжилт, тайлагнал эдгээртэй холбоотой мөнгөн болон бусад гүйлгээ хамаарна: 3.2.1.улс, орон нутгийн төсөв болон Нийгмийн даатгалын сангийн төсөв; 3.2.3.Засгийн газрын тусгай сан; 3.2.5.Засгийн газар, орон нутгийн өрийн бичиг, санхүүгийн бусад хэрэгсэл; 3.2.8.Засгийн газар, орон нутгийн баталгаа болон төсвийн өр, авлага үүсгэх аливаа бусад шийдвэр. 3.4.Төрийн нууцад хамаарахаас бусад төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, хэрэгжилт, тайлагналыг байгууллагын нууцад хамааруулан нийтэд мэдээлэхээс зайлсхийхийг хориглоно.	Практикт нийцэж байгаа байдал Хүлээн зөвшөөрөгдсөн байдал	- Хуулийг хэрэгжүүлэгч субъектийг зөв тодорхойлсон эсэх, бусад хууль тогтоомжуудаар тодорхойлсон этгээдүүдэд хэрхэн уялдаж байгааг тодорхойлно. - Хамрах хүрээнд багтаж буй санхүүгийн мэдээллүүд нь практикт хуулийн зорилтыг хангахуйц хэмжээнд хамаарч чадаж байгаа эсэхийг тодруулах,
2.	6 дугаар зүйл. Шилэн дансны мэдээлэл 6.1.Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ: 6.1.1.тухайн жилийн төсөв, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлтийг жил бүрийн 01 дүгээр сарын 10-ны өдрийн дотор;	Практикт нийцэж байгаа байдал	хууль хэрэгжүүлэх явцад тулгамдаж буй асуудлыг тогтоох, Хэрэгжүүлэгчийн зүгээс хэрхэн хүлээн авч, биелүүлж байгааг тодорхойлох,

	6.1.2.хагас жилийн төсвийн гүйцэтгэлийг жил бүрийн 08 дугаар сарын 15-ны өдрийн дотор, өмнөх оны төсвийн гүйцэтгэлийг жил бүрийн 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор, сар, улирлын гүйцэтгэлийг дараа сарын 08-ны өдрийн дотор; 6.1.3.дараа жилийн төсвийн төслийг жил бүрийн 09 дүгээр сарын 15-ны өдрийн дотор; 6.1.4.жилийн эцсийн санхүүгийн тайланг дараа жилийн 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор, хагас жилийн тайланг 08 дугаар сарын 15-ны өдрийн дотор; 6.1.5.төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн багцад хийсэн аудитын дүгнэлтийг бүрэн эхээр нь тухайн жилийн 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор, аудитын тайлан, дүгнэлтэд тусгагдсан асуудлаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээг тухайн жилийн 07 дугаар сарын 01-ний өдрийн дотор; 6.1.6.төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбарыг улирал бүр.	Хүлээн зөвшөөрөгдсөн байдал	
	6.2.Энэ хуулийн 6.1.1-д заасан мэдээлэл дараах байдлаар илэрхийлэгдсэн байна: 6.2.1.эрх бүхий байгууллагаас баталсан жилийн төсөв, гүйцэтгэлийг хэмжих шалгуур үзүүлэлт; 6.2.2.орлого /үндсэн үйл ажиллагааны орлого, төсөвт байгууллагын өөрийн орлого/; 6.2.3.урсгал зардал /цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэл, бусад урсгал зардал, хөрөнгийн зардал, татаас шилжүүлэг/; 6.2.4.хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, концессын зүйлийн жагсаалт; 6.2.5.улсын төсөв болон орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлого, тэдгээрийн задаргаа; 6.2.6.зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр /улсын төсөв, орон нутгийн төсөв, өөрийн орлого/.	Практикт нийцэж байгаа байдал,	хууль хэрэгжүүлэх явцад тулгамдаж буй асуудлыг тогтоох,
	6.3.Энэ хуулийн 6.1.2-т заасан мэдээлэл дараах байдлаар илэрхийлэгдсэн байна: 6.3.1.Төсвийн ерөнхийлөн захирагчийн энэ хуулийн 6.2.1-д тодорхойлсон	Практикт нийцэж байгаа байдал	хууль хэрэгжүүлэх явцад тулгамдаж буй асуудлыг тогтоох,

үзүүлэлт, хүрсэн үр дүн, хэрэгжилтийг хэмжих тоон болон чанарын үзүүлэлт; 6.3.2.төсвийн гүйцэтгэлийг батлагдсан төсвийн төлөвлөгөөтэй харьцуулсан харьцуулалт; 6.3.3.төсөв хэмнэсэн болон хэтэрсэн бол холбогдох шалтгааныг тайлбарласан тайлбар; 6.3.4.өмнөх оны төсвийн зарлагын хэмнэлт, туслах үйл ажиллагааны орлогын давсан хэсгийг урамшуулалд зарцуулсан бол зориулалтыг заасан байх; 6.3.5.хандив, тусламжийн хэмжээ, түүний зарцуулалт; 6.3.6.хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээг тендер зарлаж, сонгон шалгаруулсан бол шалгаруулалтын ерөнхий мэдээлэл; 6.3.7.хөрөнгө оруулалтын зарлага, санхүүжилтийг төсөл, объект тус бүрээр; 6.3.8.тусгай сангийн орлого, зарлага, хөрөнгө оруулалт; 6.3.9.орон нутгийн хөгжлийн сангийн гүйцэтгэл.		
6.4.Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ: 6.4.1.тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт; 6.4.2.тухайн байгууллагын хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээнд орсон өөрчлөлт; 6.4.3.тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилга, тендерт оролцохыг сонирхогчид тавих шалгуур үзүүлэлт, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгаан; 6.4.4.таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг; 6.4.5.цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус	Практикт нийцэж байгаа байдал,	хууль хэрэгжүүлэх явцад тулгамдаж буй асуудлыг тогтоох,

бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр; 6.4.6.худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт шалгалтын дүн; 6.4.7.байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлт; 6.4.8.бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс,төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр; 6.4.9.хууль тогтоомжид заасан бусад мэдээлэл.		
6.5.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага энэ хуулийн 6.1, 6.4-т заасан мэдээллээс гадна дараах мэдээллийг гаргана: 6.5.1.улсын төсөв, Нийгмийн даатгалын сангийн төсвийн орлого, зарлага, хөрөнгө оруулалт, төсвийн нэгдсэн үзүүлэлтийг хагас жилийн байдлаар тухайн жилийн 07 дугаар сарын 15-ны өдрийн дотор, жилийн эцсийн байдлаар дараа жилийн 01 дүгээр сарын 15-ны өдрийн дотор; 6.5.2.Засгийн газрын гадаад зээл, тусламжийн ашиглалтын мэдээг улирал бүр; 6.5.3.Засгийн газрын гадаад, дотоод өрийн мэдээллийг улирал бүр; 6.5.4.улсын төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбарыг улирал бүр; 6.5.5.нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээг сар бүрийн 15-ны өдрийн дотор; 6.5.6.төсвийн гүйцэтгэл болон аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайланг дараа жилийн 08 дугаар сарын 25-ны өдрийн дотор; 6.5.7.төсвийн алдагдлыг санхүүжүүлэх зорилгоор гаргасан Засгийн газрын дотоод үнэт цаасны мэдээллийг улирал бүр. 6.5.8.концессын зүйлийн жагсаалт болон түүнд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг батлагдсанаас нь хойш долоо хоногийн дотор;	Хүлээн зөвшөөрөгдсөн байдал	Хэрэгжүүлэгчийн зүгээс хэрхэн хүлээн авч, биелүүлж байгааг тодорхойлох,

6.5.9.концессын гэрээ болон түүнд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг гэрээ байгуулагдсанаас нь хойш долоо хоногийн дотор; 6.5.10.концессын гэрээ байгуулсан тухай бүрд концесс эзэмшигч, түүний байгууллагын нууцад хамаарахаас бусад мэдээлэл, концессын зүйл, гүйцэтгэх ажил, үзүүлэх үйлчилгээний талаарх мэдээллийг долоо хоногийн дотор; 6.5.11.хөрөнгө оруулалтыг санхүүжүүлэх зорилгоор гаргасан Засгийн газрын гадаад үнэт цаасны мэдээллийг улирал бүр; 6.5.12.улсын төсвийн нэгдсэн үзүүлэлтийг макро эдийн засгийн үзүүлэлт, холбогдох бусад үзүүлэлттэй уялдуулсан судалгаа, тооцоог улирал бүр.		
6.8.Энэ хуулийн 3.1.3-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ: 6.8.1.тухайн байгууллагад холбогдох энэ хуулийн 3.2.5, 3.2.7, 3.2.8-д заасан шийдвэр; 6.8.2.худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилга, тендерт оролцохыг сонирхогчдод тавих шалгуур үзүүлэлт, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгаан; 6.8.3.төр болон орон нутаг тавь буюу түүнээс дээш хувийг эзэмшиж байгаа компанийн гаргасан их хэмжээний хэлцэлд тооцогдохуйц баталгаа, батлан даалт.	Практикт нийцэж байгаа байдал	хууль хэрэгжүүлэх явцад тулгамдаж буй асуудлыг тогтоох,
6.9.Арван сая төгрөгөөс дээш үнийн дүнгээр улс, орон нутгийн төсөв, Засгийн газрын болон орон нутгийн тусгай зориулалтын сан, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалт, санхүүжилт, Засгийн газар, түүний харьяа байгууллагаас гаргасан бонд, үнэт цаас, өрийн бичиг, баталгаа, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээний дагуу хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөр, арга хэмжээний дагуу санхүүжиж байгаа энэ хуулийн 3.1.4, 3.1.5-д заасан этгээд нь нийт төсөвт өртөг, хэрэгжилтийн явц, үе шат, зарлага,	Практикт нийцэж байгаа байдал	хууль хэрэгжүүлэх явцад тулгамдаж буй асуудлыг тогтоох,

	санхүүжилтийн мэдээллийг Засгийн газраас тогтоосон журмын дагуу улирал бүр хөрөнгө оруулалт, санхүүжилтээ хүлээн авсан төсвийн байгууллагын цахим хуудас, мэдээллийн самбар, шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд байрлуулах ба шаардлагатай гэж үзвэл олон нийтийн бусад цахим хуудас, өөрийн цахим хуудсаар давхар мэдээлж болно. Мэдээллийг төсвийн байгууллагын цахим хуудас, мэдээллийн самбар, шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд байрлуулахад энэ хуулийн 3.1.4, 3.1.5-д заасан этгээд төлбөр төлөхгүй.		
	6.10.Шилэн дансны мэдээлэл, зарлагын гүйлгээ бүрд түүнд холбогдох эрх бүхий этгээдийн шийдвэрийн эх хуулбар, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдлийг хавсаргасан байна.	Практикт нийцэж байгаа байдал Хүлээн зөвшөөрөгдсөн байдал	хууль хэрэгжүүлэх явцад тулгамдаж буй асуудлыг тогтоох, Хэрэгжүүлэгчийн зүгээс хэрхэн хүлээн авч, биелүүлж байгааг тодорхойлох,
3.	8 дугаар зүйл. Хуулийн хэрэгжилтэд тавих хяналт 8.2.Энэ хуулийн 3.1.1-д заасан төсвийн байгууллага, албан тушаалтны шилэн дансны үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлд заасны дагуу төсвийн ерөнхийлөн захирагч хэрэгжүүлнэ.	Практикт нийцэж байгаа байдал	Хуулийн үйлчлэх хүрээг бүхэлд нь хангахуйц хяналтыг хэрэгжүүлж байгаа эсэхийг тогтоох,
4.	10 дугаар зүйл. Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага 10.1.Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.	зорилгод хүрсэн түвшин,	Хуулийн зорилтыг хангахуйц хөшүүрэг болж байгаа эсэх, бүрэн гүйцэд оновчтой эсэхийг тодорхойлно.

1.6. Мэдээлэл цуглуулах аргыг сонгох:

Энэхүү үнэлгээг хийхэд тоон болон чанарын мэдээллийг аль алиныг нь ашигласан бөгөөд үнэлгээний хүрээнд хамаарах Шилэн дансны тухай хуулийн зүйл бүрийн шалгуур үзүүлэлт, түүний томъёолол ялгаатай байгаатай холбоотойгоор өмнө нь хийгдсэн судалгааны тайлан, дүгнэлт, зөвлөмж зэрэг мэдээлэл цуглуулах аргыг ашигласан болно.

ХОЁР.ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ

Хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийхэд дараах мэдээллүүдийг эх сурвалж болгон ашиглав. Үүнд:

1. Монгол Улсын Ерөнхий сайдын 2018 оны 9 дүгээр сарын 11-ний өдрийн 154 дүгээр захирамжаар Шилэн дансны тухай хуулийг бусад хууль тогтоомжид нийцүүлэх, нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөл боловсруулах ажлын хэсгийг байгуулсан бөгөөд Сангийн яамны Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар дэд ажлын хэсэг байгуулж, Европын холбооны буцалтгүй тусламжийн санхүүжилтээр Дэлхийн банктай хамтран хэрэгжүүлж буй “Монгол улсад засаглалыг бэхжүүлэх төсөл”-ийн хүрээнд Шилэн дансны эрх зүйн орчин, ШДНЦХ-ыг боловсронгуй болгох чиглэлээр зөвлөх үйлчилгээ авч ажиллуулсан.

Зөвлөх үйлчилгээний хүрээнд хийсэн “Шилэн дансны хууль, журмын хэрэгжилт, системийн ашиглалтын өнөөгийн байдал, тулгарч буй хүндрэл бэрхшээл, сайжруулах арга замыг тодорхойлох” зорилго бүхий судалгаа болон Шилэн дансны тухай хууль, эрх зүйн орчинд хийсэн дүн шинжилгээний судалгааны тайланг ашигласан.

2. Шилэн дансны тухай хуулийн 8 дугаар зүйлд заасны дагуу Үндэсний аудитын газрын “Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт”-д хийсэн нийцлийн аудитын тайлангуудыг судалж тоон болон чанарын мэдээллүүдэд дүн шинжилгээ хийсэн. Үүнд:

1. ЯАГ- НАГ/2015/04-НА кодтой “Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт”-д хийсэн нийцлийн аудитын тайлан,
2. ЯАГ- НАГ/2016/ 04-НА кодтой “Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт”-д хийсэн нийцлийн аудитын тайлан,
3. ЯАГ- НАГ/2017/03-НА кодтой “Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт”-д хийсэн нийцлийн аудитын тайлан,
4. ЯАГ- НАГ/2018 /01-НА кодтой “Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт”-д хийсэн нийцлийн аудитын тайлан,
5. ЯАГ- НАГ/2019 /01-НА кодтой “Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт”-д хийсэн нийцлийн аудитын тайлан,
6. ЯАГ-НАГ/2020/01-НА кодтой “Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт”-д хийсэн нийцлийн аудитын тайлан.

3. Үнэлгээ хийхэд судалсан Монгол Улсын хууль:

1. Монгол Улсын Үндсэн хууль,
2. Төсвийн тухай хууль,
3. Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль,
4. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль,
5. Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль,
6. Зөрчлийн тухай хууль,
7. Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль,
8. Төрийн албаны тухай хууль,
9. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль,
10. Төрийн болон албаны нууцын тухай хууль,
11. Засгийн газрын тусгай сангийн тухай,

12. Концессын тухай,
13. Төсвийн тогтвортой байдлын тухай,
14. Төрийн аудитын тухай,
15. Аудитын тухай,
16. Нягтлан бодох бүртгэлийн тухай,
17. Төрийн хяналт шалгалтын тухай,
18. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай,
19. Компанийн тухай,
20. Үнэт цаасны зах зээлийн тухай хууль,
21. Банкны тухай хууль,
22. Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль,
23. Даатгалын тухай хууль,
24. Захиргааны ерөнхий хууль,
25. Иргэний хууль,
26. Хөдөлмөрийн тухай хууль,
27. Байгууллагын нууцын тухай хууль.

ГУРАВ.ҮНЭЛЭХ ҮЕ ШАТ

3.1.Мэдээллийг үнэлсэн байдал:

Дээр дурдсан үнэлгээний хэрэгжүүлэх үе шатанд цуглуулж, ашигласан тоон болон чанарын мэдээлэл нь үнэлгээний хүрээнд хамаарах Шилэн дансны тухай хуулийн зүйл, заалтын хэрэгжилтийг үнэлэхэд хангалттай, бодитой бөгөөд хамааралтай байсан болно.

3.2.Шалгуур үзүүлэлт, харьцуулах хэлбэрийг ашиглан үнэлсэн байдал.

3.2.1. 3 дугаар зүйлийн (субъектийн) хэрэгжилтийн үнэлгээний талаар:

3 дугаар зүйл. Хуулийн үйлчлэх хүрээ

3.1.Доор дурдсан байгууллага, түүний эд хөрөнгө захиран зарцуулах эрх бүхий албан тушаалтан энэ хуулийн үйлчлэлд хамаарна:

3.1.1.төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд;

3.1.2.төрийн өмчит үйлдвэрийн газар;

3.1.3.хяналтын багц буюу түүнээс дээш хэмжээний хувьцааг нь төр, орон нутаг болон тэдгээрийн нэгдмэл сонирхолтой этгээд эзэмшиж байгаа компани;

3.1.4.улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөр, арга хэмжээ, ажил, үйлчилгээ гүйцэтгэж байгаа аж ахуйн нэгж, байгууллага;

3.1.5.төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг хууль тогтоомж, гэрээний үндсэн дээр гүйцэтгэгч. гэж заасан байна.

Хуулийн үйлчлэх хүрээнд хамрагдах байгууллагын ангилал нь улсын бүртгэлийн ангиллыг баримтлаагүй, өмчийн ангилал, компанийн хяналтын багц, хариуцлагын хэлбэр зэрэг олон хувилбарыг хольсон бөгөөд ялгаатай мэдээлэл байршуулахаар зохицуулсан нь байгууллагууд аль ангилалд хамаарч ямар мэдээлэл байршуулах дээр зөрүүтэй ойлголтыг төрүүлэхээр байна.

Төрийн байгууллагыг бусад хууль тогтоомжоор ашгийн төлөө бус хуулийн этгээд, төсөвт байгууллага гэх зэргээр томьёолсон бөгөөд Монгол Улсын Үндсэн хуульд “байгууллага” гэх нэр томьёог хэрэглэсэн.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиар Үндсэн хууль, Иргэний хуульд тодорхойлсон төрийн болон орон нутгийн өмчийн өмчлөх эрхийг хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахаар хуульчилсан. Тус хуулийн 13 дугаар зүйлд “Төр чиг үүргээ хэрэгжүүлэх болон нийгмийн хэрэгцээг хангах зорилгоор төр өөрийн өмчөөр дангаараа байгуулсан хуулийн этгээдийг төрийн өмчит хуулийн этгээд гэнэ. Төрийн өмчит хуулийн этгээдийг эд хөрөнгийн эрхийн байдлаар нь 1/ төрийн байгууллага, албан газар; 2/ төрийн өмчит үйлдвэрийн газар гэж, мөн 21 дүгээр зүйлд 1. Төрийн өмчийн хувьцаатай буюу төр хувь хөрөнгөө оруулсан хуулийн этгээдийг төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд гэнэ.” гэж

тус тус заасантай Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсэгт заасан ангилал нийцэхгүй байна.

Улсын бүртгэлийн байгууллага:

Улсын бүртгэлийн байгууллага дараахь хуулийн этгээд, түүний салбар, төлөөлөгчийн газрыг бүртгэх бөгөөд гэрчилгээг хариуцлагын хэлбэрээр нь индексжүүлж олгодог. *Зураг 3-аас харах.*

хувийн эрх зүй дэх хуулийн этгээд	нийтийн эрх зүй дэх хуулийн этгээд
7.1.1.нөхөрлөл;	7.1.6.шашны байгууллага;
7.1.2.компани;	7.1.7.нийтийн эрх зүйн хуулийн этгээд;
7.1.3.холбоо /төрийн бус байгууллага/;	7.1.8.төрийн байгууллага, албан газар;
7.1.4.сан;	7.1.9.улсын төсөвт үйлдвэрийн газар;
7.1.5.хоршоо;	7.1.10.аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар.

Иргэний хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсэгт “Өмчлөлдөө буюу эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхдээ тусгайлсан хөрөнгөтэй, өөрийн нэрээр эрх олж, үүрэг хүлээдэг, үйл ажиллагаанаасаа бий болох үр дагаврыг эд хөрөнгөөрөө хариуцдаг, нэхэмжлэгч, хариуцагч байж чадах, тодорхой зорилго бүхий, тогтвортой үйл ажиллагаа эрхэлдэг зохион байгуулалтын нэгдлийг хуулийн этгээд гэнэ” гэж тодорхойлсон бөгөөд хуулийн этгээд нь ашиг олох зорилготой ашгийн төлөө, хууль буюу дүрэмд заасан зорилготой, ашгийн төлөө бус байж болно. Хуулийн этгээд нь нийтийн, хувийн, холимог өмчийн байна.

Харин хуулийн этгээдийн иргэний эрх зүйн чадвар нь улсын бүртгэлд бүртгүүлснээр үүсч, хуульд заасан журмын дагуу татан буугдаж, улсын бүртгэлээс хасагдсанаар дуусгавар болохоор Иргэний хуулийн 26 дугаар зүйлийн 26.1 дэх хэсэгт заасан.

Зураг 1. Гэрчилгээ болон хэлбэрийн индексийн уялдаа

Хувийн хэргийн дугаар: 9 орон
Эхний 2 орон – аймаг, УБ
Дараагийн 2 орон хариуцлагын

8 оронтой тоо:
Регистрийн дугаар

Үйл ажиллагааны чиглэл бичгээр


Үйл ажиллагааны чиглэл код
4 оронтой: СЯ болон ҮСХ
хамтарсан тушаал.

Жишээлбэл: Хувийн хэргийн дугаар 90 71 09 6139 бол 90 – УБ хот, 71- Нийгэмд үйлчилдэг төрийн бус байгууллага гэдгийг илэрхийлнэ. Иймд регистрийн дугаараас гадна хувийн хэргийн дугаарыг нэмж бүртгэхээр бүртгэлийн маягтад оруулсан.

Үндэсний статистикийн хорооноос дараахь байдлаар байгууллагыг ангилдаг.

Өмчийн хэлбэрээр: Өмчөөр нь байгууллагыг төрийн, хувийн гэж үндсэн хоёр төрлөөр ангилах ба төрийн өмчийн байгууллагыг дараахь байдлаар ангилдаг.

- төрийн / орон нутгийн өмчит – өмч нь 100 хувь төрийн эсхүл орон нутгийн өмчид хамаарна.
- төрийн / орон нутгийн өмчийн өмчийн оролцоотой.



Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйл. Төрийн өмчийн талаархи Засгийн газрын бүрэн эрх 5/ хуульд өөрөөр заагаагүй бол төрийн өмчит хуулийн этгээдийг байгуулах, өөрчлөх, татан буулгах тухай шийдвэр гаргах, түүний дүрмийг батлах” дагуу, хувьчлах бол тус хуулийн 33, 46-54 дүгээр зүйлийг үндэслэл болгож байна.

Эх сурвалж: 1. 25 дугаар ТВ-ийн 168 цаг мэдээллийн хөтөлбөр, 2020 он 11 сар

Хариуцлагын хэлбэрээр:

- Нөхөрлөл: Бүх гишүүд нь бүрэн хариуцлагатай нөхөрлөл (ББН), зарим гишүүд нь бүрэн хариуцлагатай нөхөрлөл (ЗБН)
- Хоршоо
- Компани¹: Хувьцаат компани (ХК), хязгаарлагдмал хариуцлагатай компани (ХХК) хэлбэртэй. Хувьцаат компани нь нээлттэй, хаалттай гэсэн төрөлтэй.
- Төрийн өмчит үйлдвэрийн газар (ТӨҮГ), орон нутгийн өмчит үйлдвэрийн газар (ОНӨҮГ)
- төсвийн байгууллага (ТБ)
- төрийн бус байгууллага (ТББ)
- Бусад гэж ангилдаг: Бусад төрлийн ангилалд хувийн сургууль, эмнэлэг, сонин, хэвлэлийн газар гэх мэт хариуцлагын хэлбэрээр ангилах боломжгүй нэгжүүдийг хамруулсан.

Компанийн талаар:

¹ 3.5. **Хязгаарлагдмал хариуцлагатай компани** гэж хувьцаа эзэмшигчийн оруулсан хөрөнгө нь хувьцаанд хуваагдаж, түүнийг захиран зарцуулах эрх нь хууль болон компанийн дүрмээр хязгаарлагддаг компанийг хэлнэ.

3.7. **"Нээлттэй хувьцаат компани"** гэж хувьцаа эзэмшигчийн оруулсан хөрөнгө нь хувьцаанд хуваагдаж, хувьцаа нь үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагад бүртгэгдэж, **нийтэд чөлөөтэй арилжаалагддаг** компанийг хэлнэ.

3.8. **"Хаалттай хувьцаат компани"** гэж хувьцаа эзэмшигчийн оруулсан хөрөнгө нь хувьцаанд хуваагдаж, хувьцаа нь үнэт цаасны хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэх байгууллагад бүртгэгдэж, үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагаас гадуур зах зээлд **хаалттай хүрээнд арилжаалагддаг** компанийг хэлнэ.

- Хууль тогтоомжийн хувьд: Компанийн тухай хууль 2011, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль 2013, Банкны тухай хууль 2010, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль 2002, Даатгалын тухай хууль 2004 түлхүү хамаарна.
- Хяналтын багц: Компанийн тухай хууль 56 дугаар зүйлийн 56.1-д “Компанийн гаргасан энгийн хувьцааны гуравны нэг буюу түүнээс дээш хэмжээний хувьцааг компанийн хувьцааны хяналтын багц гэнэ” гэж заасан. Хяналтын багц нь төрийн болон орон нутгийн өмчийн эзэмших хувь хэмжээнээс ялгаатай ойлголт бөгөөд тогтворгүй /зарж борлуулж болдог тул эзэмшигч өөрчлөгдөх аюултай/ байдаг тул өмчийн ангиллыг барихыг санал болгож байна.
- Хараат болон охин компани, компанийн нэгдэл:
 - Компанийн нийт гаргасан энгийн хувьцааны 20-50 хувийг өөр /толгой/ компани дангаараа буюу нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран эзэмшиж байгаа тохиолдолд уг компанийг хараат компани гэнэ.
 - Компанийн нийт гаргасан энгийн хувьцааны 50-аас дээш хувийг өөр /толгой/ компани дангаараа буюу нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран эзэмшдэг бие даасан компанийг охин компани гэнэ.
 - Нэг толгой компанийн хараат болон охин компаниуд, эсхүл нэг этгээд дангаараа болон нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран хувьцааных нь хяналтын багцыг эзэмшдэг компаниудыг зэргэлдээ компани гэнэ.

Шилэн дансны хуулиас гадна дараахь хуулиудаар компанийн ил тод байдлыг зохицуулж байна. Энэ нь ШДНЦХ-д мэдээлэл байршуулж буй байгууллагуудын хувьд олон газарт, ялгаатай систем дээр харилцан адилгүй хугацаанд мэдээлэл бэлтгэн байршуулахад хүргэж байна.

Хүснэгт 4. Компанийн ил тод байдал

	Байгууллагын төрөл	Нийтэд мэдээлэх зүйл	Нийтэд мэдээлэл хугацаа	Нийтэд мэдээлэх арга	Хяналт тавих байгууллага
1	Хувьцаат компани	Санхүүгийн тайлан, бусад	Дараа жилийн 1 дүгээр улирал /аудитаар баталгаажсан/.,	Компанийн болон МХБ-ийн цахим хуудас	СЗХ, Монголын хөрөнгийн бирж
2	Банк /үйл ажиллагааны хэлбэр/ Зохион байгуулалтын хэлбэр	Санхүүгийн тайлан, бусад	Дараа жилийн 1 дүгээр улирал /аудитаар баталгаажсан/.,	Олон нийтийн хэвлэл “цахим хуудас”	Монголбанк

3	Банк бус санхүүгийн байгууллага	Санхүүгийн тайлан	Дараа жилийн 1 дүгээр улирал /аудитаар баталгаажсан/	Олон нийтийн хэвлэл “цахим хуудас”	СЗХ
4	Даатгалын компани	Санхүүгийн тайлан	Дараа жилийн 1 дүгээр улирал /аудитаар баталгаажсан/	Олон нийтийн хэвлэл “цахим хуудас”	СЗХ

Дүгнэлт: Хуулийн үйлчлэх хүрээний субъектийн зохицуулалтын хэрэгжилтийг практикт нийцэж байгаа байдал шалгуур үзүүлэлтээр үнэлэхэд хууль тогтоомж хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш нөхцөл байдал өөрчлөгдсөн буюу Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй бусад хууль тогтоомжийн зохицуулалтын уялдаа холбоо, шинэ тутам бий болсон зохицуулалтуудтай зөрчилдөж байна.

Тухайлбал, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиар 13 дугаар зүйл, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэгт тус тус төрийн байгууллага, албан газар; төрийн өмчит үйлдвэрийн газар буюу улсын төсөвт үйлдвэрийн газар, аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар гэх ангиллаар төрийн өмчит хуулийн этгээдийн ойлголт, ангиллыг тогтоосон. Захиргааны ерөнхий хуулийн 5 дугаар зүйлд захиргааны байгууллага гэх ойлголтыг нарийвчлан тогтоосон бөгөөд энэхүү зохицуулалт нь Шилэн дансны тухай хууль батлагдсанаас хойш хийгдсэн тул Шилэн дансны тухай хуулийн үйлчлэлд хамаарах субъектийг оновчтой тодорхойлоход анхаарах нь зүйтэй байна.

Иргэний хуулийн 25 дугаар зүйлийн 25.1-д заасан шинжийг агуулсан зохион байгуулалтын нэгдлийг хуулийн этгээд гэнэ. Хуулийн этгээдийн иргэний эрх зүйн чадвар улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлснээр үүсэхээр хуульчлагдсан бөгөөд энэ харилцааг Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулиар зохицуулдаг.

Харин Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 5.2-т “Хуулийн этгээд улсын бүртгэлд бүртгүүлэхээсээ өмнө иргэний эрх зүйн харилцаанд оролцохыг хориглоно” гэж заасан.

Гэвч Монгол Улсад тодорхой төрлийн үйл ажиллагаа эрхэлж, өмч, хөрөнгө захиран зарцуулж буй хуулийн этгээдийн шинжийг агуулсан зарим (сан, төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэгч байгууллага гэх мэт) субъект банкинд данс эзэмшиж гүйлгээ хийдэг, татварын байгууллагад бүртгэлтэй, тайлан гаргадаг атал улсын бүртгэлд бүртгүүлээгүй байна.

Энэ нь нэг талаас дээр дурдсан төрлийн байгууллагуудыг Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд заасан хуулийн этгээдийн төрөлд бүрэн хамруулж нарийвчилж тодорхойлоогүй, эсхүл бүртгэлийн эрх бүхий байгууллагаас хуулийн хэрэгжилтийг хангуулж бүртгэл хийх явцдаа хуулийг буруу ойлгож хэрэглэж бүртгэл хийдэггүйтэй холбоотой гэж үзэхээр байна.

Мөн түүнчлэн Хуулийн этгээдийн бүртгэлийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.5-д “Энэ хуулийн 7.1.8, 7.1.9-д олон улсын байгууллага, Засгийн газрын тусгай сан, комисс, хороо, үндэсний зөвлөл хамаарахгүй бөгөөд улсын бүртгэлд бүртгэхгүй” гэж зааснаар зарим байгууллагуудад бүртгэл хийдэггүй байгаа нь учир дутагдалтай байна.

Энэ нь Иргэний хуулийн 26 дугаар зүйлийн 26.3-т “Нийтийн эрх зүйн хуулийн этгээдийн иргэний эрх зүйн чадвар хуульд заасан журмаар байгуулагдсанаар үүсч, татан буугдсанаар дуусгавар болох бөгөөд иргэний эрх зүйн харилцаанд бусад оролцогчтой адил тэгш эрхтэй оролцоно” гэсний хүрээнд хуульд заасан үндэслэлээр байгуулагдах байх тул бүртгэлд бүртгүүлэх шаардлагагүйтэй холбоотой юм. Монгол Улсад төсвийн байгууллагын иж бүрэн ангилал байхгүйн дээр улсын бүртгэлийн ангилалтай зөрчилдөж байна. Төрийн сангаар гүйлгээ хийдэг төсвийн байгууллагын хувьд улсын бүртгэлд бүртгүүлсэн гэрчилгээтэй, эсхүл бүртгүүлээгүй улсын бүртгэлийн гэрчилгээгүй байгууллага байгаа боловч регистрийн дугаар олгогдсон (төсөл, хөтөлбөр), бие даасан бүтэцгүй нэгж хэлбэртэй, засгийн газрын тусгай сан /данс/, аль нэг байгууллагын салбар, нэгж, төлөөлөгчийн газар зэрэг байгууллагын статус байхгүй ч бие даасан данстай үйл ажиллагаа явуулдаг ажлын алба зэрэг олон хэлбэртэй байна. Мөн түүнчлэн Сангийн яамны систем нь байгууллагаар биш дансаар бүртгэгдэг тул ангиллыг гаргахад хүндрэлтэй байна. Хавсралт-1 дахь хүснэгтээс байгууллагуудын дэлгэрэнгүйг харна уу.



Төсвийн тухай хуулиар баталсан төсвийн шатлал, нийтлэг мөрдөж буй ангилал нь олон улсын GFS (government financial statistical) ангилалтай бүрэн нийцээгүй. GFS дагуу Монгол Улсын зарим нэг байгууллагыг хэрхэн ангилах талаар Самвел, Мөнхбаяр² нарын тайланд дэлгэрэнгүй оруулсан бөгөөд ангиллын суурь зарчим нь төсвөөс авч буй санхүүжилтийн хувь, хэмжээг ангиллын суурь үзүүлэлт болгодог.

Дээрх ангиллаас гадна дараахь эрх зүйн материалуудыг нэмж судлан ШДНЦХ-д мэдээлэл байршуулах байгууллагын ангилал болон хуулийн үйлчлэх хүрээг, Сангийн яамны төсөв, санхүүгийн системд нийцүүлэн санал болгосон. Зураг

² Samvel Markosyan (SNKE), Munkhbayar Tsedevsuren (JNKE), Improve Government Accounting and Reporting on Unreported Government Operations, The European Union, Economic Governance for Equitable Growth (EG4EG) Project, Mongolia, 2018

5-д харуулсан ангилал нь ШДНЦХ-д байгууллагыг бүртгэх бүртгэлийн маягтын ангилал бөгөөд ерөнхийгөөс нарийвчилсан байдлаар бүртгэгдэнэ.

Хууль	Журам
Төсвийн тухай хууль	- Сангийн сайдын 2015 оны 12 сарын 17 өдрийн 341 тоот тушаал, ТЕЗ болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга - Сангийн сайдын 2014 оны 1 сарын 10 өдрийн 5 тоот тушаал, Эдийн засгийн ангилал - Сангийн сайдын 2015 оны 1 сарын 20 өдрийн 7 тоот тушаал, Төсвийн ангилал шинэчлэн батлах тухай - Сангийн сайдын 2005 оны 10 сарын 17 өдрийн 276 тоот тушаал, Дансны жагсаалт батлах тухай
Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль	- Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн үйл ажиллагаанд хэрэглэх маягтын загвар, индекс, код батлах тухай /УБЕГ-ын даргын А/55 дугаар тушаал/ /2021.02.08/ - Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2018 оны А/420 дугаар тушаалын “Хуулийн этгээдийн хэлбэрийн индекс” 16 дугаар хавсралт, “Улсын бүртгэлийн байгууллагын бүртгэх код” 17 дугаар хавсралт, - Хуулийн этгээд, түүний салбар, төлөөлөгчийн газрын улсын бүртгэл хөтлөх журам /Хууль зүй, дотоод хэргийн сайдын А/208 дугаар тушаал/ /2018.11.01/ - Хуулийн этгээдийн хувийн хэрэг хөтлөх журам /УБЕГ-ын А/1050 дугаар тушаал/ /2019.10.22/ - Татвар төлөгчийн бүртгэлийн журам /Татварын ерөнхий газрын дарга, УБЕГ-ын даргын А/268; А/1345 дугаар хамтарсан тушаал/ /2019.12.30/
Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн тухай	Монгол улсын засгийн газрын 80 тогтоол, 2016 оны 9 сарын 7 өдөр, Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх журам
Компанийн тухай	Хуулийн этгээдийн улсын бүртгэлтэй ижил зохицуулалттай.
Засгийн газрын тусгай сан	Улсын бүртгэлд бүртгэгдэггүй.

Үндэсний Аудитын газраас өгсөн зөвлөмж:

Хууль, тогтоомж, гэрээний үндсэн дээр төрийн чиг үүргийг хэрэгжүүлж байгаа байгууллагуудыг шилэн дансны цахим хуудсанд бүртгүүлэх ажлыг хэрэгжүүлж байгаа боловч хуулийн энэхүү ангиллын нарийвчилсан тодорхойлолт, тэдгээрийг бүртгэх нэгдсэн тогтолцоо байхгүй зэргээс шалтгаалан шилэн дансны нэгдсэн бүртгэлд бүрэн хамруулж чадаагүй байна.

Төрийн чиг үүрэгт хамаарах ажил үйлчилгээг гэрээний үндсэн дээр гүйцэтгэгч байгууллага болон улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр ажил, үйлчилгээ үзүүлж буй ААНБ-ын тодорхойлолт, эрх, үүрэг, тэдгээрийг шилэн дансанд бүртгэх, мэдээлэл оруулах, хасах нөхцөл, шаардлагыг журмаар нарийвчлан зохицуулах;

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-т төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, 3.1.2-т төрийн өмчит үйлдвэрийн газар хуулийн үйлчлэлд хамаарахаар давхардуулсан, давхардлыг арилгах,

Жил бүрийн 12 сард дараа жилд Шилэн дансны тухай хуулийг дагаж мөрдөх субъектийн жагсаалтыг хуулийн 3 дугаар зүйлд заасан ангиллаар гаргаж батлах, уг жагсаалтад ороогүй байгууллагуудад тухайн жилд төсөв, хөрөнгө хуваарилахгүй байх хууль эрх зүйн зохицуулалт бий болгох;

Улсын бүртгэлийн ерөнхий хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулиудын төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжийн бүртгэлтэй холбоотой зүйл, заалтуудыг уялдуулан боловсронгуй болгож тэдгээрийн бүртгэл, мэдээллийн нэгдмэл байдлыг хангах,

Зөвлөмж 1: Мэдээлэл байршуулах үүрэг бүхий этгээдийн хүрээг дараахь байдлаар тодорхойлох:

1.захиргааны байгууллага³ буюу төрийн байгууллага, албан газар⁴

2.төрийн өмчит үйлдвэрийн газар⁵

3.Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд заасан сан,

4.төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд⁶, (Компани)

5.хяналтын /хараат буюу 20 хувийг эзэмшиж байвал болгоё/ багц буюу түүнээс дээш хэмжээний хувьцааг нь төр, орон нутаг болон тэдгээрийн нэгдмэл сонирхолтой этгээд эзэмшиж байгаа компани; (4 дэх заалттай адилхан боловч тухайн төрийн өмчийн оролцоотой компани хамаарч байгаа)

6.улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөр, арга хэмжээ, ажил, үйлчилгээ гүйцэтгэж байгаа этгээд,⁷ Тайлбар: *Шилэн дансны системд мэдээлэл байршуулах үүрэг хувийн хэвшилд байх ёсгүй буюу тэрээр үүрэг хүлээх этгээд бус, харин түүний төсвийн хөрөнгө оруулалтын талаарх мэдээллийг ил байршуулах зохицуулалт хийхдээ төрийн талын субъектийг үүрэгжүүлэх нь зүйтэй байна.*

7.төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг хууль тогтоомж, гэрээний үндсэн дээр гүйцэтгэгч,⁸

8.гадаадын зээл, тусламжаар хэрэгжиж буй төсөл, хөтөлбөр, Төсвийн тухай хуулийн хүрээнд 14.2.7.өөрийн эрхлэх асуудлын хүрээний агентлаг, төсвийн бусад байгууллага,

9.дээрх этгээдүүдэд холбогдох салбар, төлөөлөгчийн газар,

Зөвлөмж 2: Шилэн дансны тухай хуулийн үйлчлэх хүрээнд хамаарах субъектийн бүртгэлийн эрх зүйн зохицуулалтын талаар.

³Захиргааны ерөнхий хуулийн 5 дугаар зүйл,

⁴ Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг,

⁵ Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 15 дугаар зүйл.

⁶ Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 1, 2 дахь хэсэг,

⁷ Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3 дахь заалт,

⁸ Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4 дэх заалт,

Шилэн дансны тухай хуулийн дагуу мэдээлэх үүрэг бүхий этгээдийн бүртгэлтэй холбоотой нарийвчилсан эрх зүйн зохицуулалт байхгүй байгаатай холбогдуулан шилэн дансны цахим хуудсаар дамжуулан бүртгэл хийх процесс ажиллагааг хийхэд хүндрэлтэй байна.

Иймээс ижил төстэй эрх зүйн зохицуулалтыг судлан үзвэл хуулийн этгээдийн бүртгэл болон татвар төлөгчийн бүртгэлийн эрх зүйн зохицуулалтаас жишээ авч Шилэн дансны тухай хуулийн дагуу мэдээлэх үүрэг бүхий этгээдийн бүртгэлийг хийх системийн шинэчлэлд ашиглахыг зөвлөж байна.

Шинээр байгуулагдсан хуулийн этгээд нь бүртгэх байгууллагаас гэрчилгээ авснаас хойш болон татварын бүртгэлийн мэдээлэлд өөрчлөлт орсноос ажлын 7 өдрийн дотор харьяалагдах татварын албанд бүр бүртгүүлдэг байна.⁹

Татварын ерөнхий хуулийн 26 дугаар зүйлийн 26.7-д “Татвар төлөгчийн бүртгэлийн журмыг татварын болон улсын бүртгэлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга хамтран батална.”¹⁰ Гэсэн байна.

Татвар төлөгчийн бүртгэлийн журамд Татвар төлөгчийг дараахь тохиолдолд татвар төлөгчийн бүртгэлээс хасах үндэслэл үүснэ. Үүнд:

- Хуулийн этгээд татан буугдсан
- Хуулийн этгээд дампуурсан тухай шүүхийн шийдвэр гарсан
- Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай тухай хуулийн 28.4 дэх заалтын дагуу бүртгэх байгууллагын саналыг үндэслэн хуулийн этгээдийн татан буулгах тухай шийдвэр гарсан
- Татвар төлөгч иргэн нас барсан, эсхүл нас барсанд тооцсон
- Хуульд заасан бусад үндэслэлээр

Татвар төлөгч хуулийн этгээд, байгууллага нь татвар төлөгчийн бүртгэлээс хасуулах тухай хүсэлтээ харьяалагдах татварын албанд албан бичгээр гаргадаг байна.

Зөрчлийн тухай хуульд бүртгэл хийлгэх үүргээ биелүүлээгүй этгээдэд хүлээлгэх хариуцлагыг дараахь байдлаар хуульчилсан байна.

⁹ Татварын ерөнхий хуулийн 26 дугаар зүйлийн 26.4. Татвар төлөгч нь татвар төлөгчийн бүртгэлийн мэдээлэл, түүний өөрчлөлт, энэ хуулийн 26.2, 26.3-т заасан мэдээллийг 7 хоногийн дотор татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд өөрөө бүртгүүлэх, эсхүл татварын албанаас мэдэгдсэнээр мөн хугацаанд баталгаажуулах үүргийг хүлээж, татвар төлөгчийн гэрчилгээнд тэмдэглүүлнэ

¹⁰ <https://www.legalinfo.mn/annex/details/10825?lawid=15197>

15.23 дугаар зүйл. Улсын бүртгэлд бүртгүүлэх журам зөрчих**1. Улсын бүртгэлд бүртгүүлэхээр мэдүүлэг гаргагч:**

- 1.1. хуульд заасан үүргээ биелүүлээгүй;
- 1.2. хуульд заасан улсын бүртгэлийн мэдүүлэг, өргөдөл, хүсэлт, хавсаргасан нотлох баримтыг үнэн зөв мэдүүлээгүй бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

11.19 дүгээр зүйл. Татварын хууль зөрчих**2. Татвар төлөгч хүн, хуулийн этгээд:**

- 2.1. хуулиар татвар төлөх, суутгах үүрэг хүлээсэн хүн, хуулийн этгээд татвар төлөгчөөр бүртгүүлэх;
- 2.2. татварын албанд хувийн хэрэг нээлгэх;
- 2.3. татварын тайланг хуулиар тогтоосон хугацаанд татварын албанд тушаах;
- 2.4. орлогоос бусад татвар ногдох зүйлийг өмчлөгч, эсхүл эзэмшигч нь уг зүйлийг өмчилж, эсхүл эзэмшиж эхэлснээс хойш хуулиар тогтоосон хугацаанд татварын албанд мэдэгдэх, хувийн хэрэг нээлгэх, хувийн хэрэгтээ өөрчлөлт хийлгэх;
- 2.5. санхүүгийн тайлан, бүртгэлийг Татварын ерөнхий хуульд заасан журмын дагуу хөтлөх;
- 2.7. төлбөрийн баримтыг татварын нэгдсэн системийн санд илгээх үүргээ биелүүлээгүй хүнийг нэг зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянга таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

3. Татвар төлөгч хүн, хуулийн этгээд:

- 3.2. хуулийн этгээдийн мэдээлэл, хувийн хэрэгт тусгагдсан зүйл өөрчлөгдөх бүрд өөрчлөлт орсноос хойш хуульд заасан хугацаанд татварын албанд мэдэгдэж, бүртгэл, хувийн хэрэгтээ өөрчлөлт хийлгэх;
- 3.3. татварын албанаас олгосон бүртгэлийн дугаарыг татварын хууль тогтоомжийн дагуу гаргаж байгаа тайлан, мэдээ, гаалийн мэдүүлэг, төлбөрийн, эсхүл шаардлагатай бусад баримтад тусгах үүргээ биелүүлээгүй бол хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

Дээрхээс дүгнэн үзвэл аливаа этгээдэд үүрэг үүсгэхэд бүртгэлийн зохицуулалт хийх зайлшгүй шаардлага үүсч байна. Энэ ч агуулгаар хуулийн этгээдийн бүртгэлийг Улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, татвар төлөгчийн бүртгэлийг Татварын ерөнхий газар хийдэг, бүртгүүлэх үүрэг бүхий этгээд энэхүү үүргээ зөрчсөн тохиолдолд Зөрчлийн тухай хуулиар хариуцлага хүлээлгэдэг эрх зүйн зохицуулалттай байна.

Түүнчлэн хуулийн этгээдийн шинжийг агуулсан байгууллагыг хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгэх эрх зүйн зохицуулалтыг холбогдох хууль тогтоомжид тусгах замаар бүрэлдүүлэх шаардлагатай.

Иймд Шилэн дансны тухай хуулийг шинэчлэн найруулах практик хэрэгцээ шаардлагуудын нэг нь Шилэн дансны тухай хуулийн дагуу мэдээлэх үүрэг бүхий этгээдийн бүртгэлтэй холбоотой зохицуулалтыг хууль болон журмаар нэмж оруулах шаардлага үүсэхээр байгаа бөгөөд бүртгүүлэх үүргийн зохицуулалтын хүрээнд хариуцлагын тогтолцоог бий болгохоор байна.

Түүнчлэн хуулийн этгээдийн шинжийг агуулсан байгууллагыг хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгэх эрх зүйн зохицуулалтыг холбогдох хууль тогтоомжид тусгах замаар бүрэлдүүлэх шаардлагатай.

3.2.2. 3 дугаар зүйлийн (мэдээлэл) хэрэгжилтийн үнэлгээний талаар:

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.2 дахь хэсэгт “Энэ хуульд дараахь төсөв, санхүүгийн үйл ажиллагааны төлөвлөлт, гүйцэтгэл, хэрэгжилт, тайлагнал эдгээртэй холбоотой мөнгөн болон бусад гүйлгээ хамаарна” гэж зааж холбогдох төрлүүдийг хуульчилсан.

Харин хуулийн 3.2.1-д “улс, орон нутгийн төсөв болон Нийгмийн даатгалын сангийн төсөв” гэж заасан нь Төсвийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д “Монгол Улсын нэгдсэн төсөв нь улсын төсөв, орон нутгийн төсөв, Нийгмийн даатгалын сангийн төсөв, Эрүүл мэндийн даатгалын сангийн төсвөөс бүрдэнэ” гэж заасантай нийцэхгүй буюу Эрүүл мэндийн санг орхигдуулсан мэт ойлголтыг төрүүлэхүйц байгаа.

Нөгөөтээгүүр хуулийн 3.2.3-т “Засгийн газрын тусгай сан” гэж хуулийн үйлчлэх хүрээнд хамруулсан бөгөөд үүнд Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн хүрээнд хамаарах бүх тусгай сан буюу нийгмийн даатгалын сан, эрүүл мэндийн даатгалын сан хамаарах тул хуулийн 3.2.1-т тусгайлан Нийгмийн даатгалын санг зөвхөн хамруулсан нь хуулийн давхардлыг үүсгэсэн байна.

Хуулийн дээрх ангиллаас 3.2.8-д “Засгийн газар, орон нутгийн баталгаа болон төсвийн өр, авлага үүсгэх аливаа бусад шийдвэр” гэсэн нь мөн хуулийн 3.2.5-т заасан ангилалтай утга, агуулгын хувьд ижил тул хууль доторх зохицуулалтын давхардлыг үүсгэсэн байна.

Тайлбар/судалгаа:


Төсвийн ангилал:

Сангийн яамны хувьд НББОУС нэвтрүүлэхээс гадна олон улсын COFOG, GFS ангилалд нийцүүлэн хөтөлбөр, зориулалтын ангиллыг боловсруулан мөрдүүлж байгаа нь сайшаалтай байна. Мөн гүйлгээг эдгээр ангиллын дагуу кодын блок үүсгэж цахимжуулсан.

- НББ-ийн олон улсын стандартыг нэвтрүүлсэн
- Олон улсын /COFOG, GFS/ ангиллыг нэвтрүүлж, дараахь эрх зүйн хүрээнд нийт 7 ангиллыг мөрдөж байна.
 - Санхүүгийн тайлангийн ангилал, Сангийн сайдын 2015-341 тоот тушаал
 - Сангийн сайдын 2015.01.20-ны өдрийн 7 тоот тушаалаар төсвийн ангиллыг шинэчлэн баталсан бөгөөд төсвийг
 - i) орлогын эдийн засаг
 - ii) зарлагын эдийн засаг
 - iii) хөтөлбөр
 - iv) зориулалт арга хэмжээгээр нь нийт дөрөв ангилсан.

- Сангийн сайдын 2014.01.10-ны 5 тоот “Эдийн засгийн ангилал батлах тухай” тушаалаар баталсан ангиллаас дараахь 2 ангиллыг хэвээр үлдээж бусдыг 2015 оны 7 тоот тушаалаар шинэчилсэн. Үүнд:
 - v) төсвийн эх үүсвэрийн ангилал
 - vi) төсвийн бусад мэдээллийн ангилал

Зураг 2. Төсвийн ангиллын уялдаа




Эдгээр ангиллыг үндсэн суурь үзүүлэлт болгон мэдээллийн урсгал болон шатлалыг тодорхойлсон. Гэхдээ хэрэгжилт дээр ангилал зөрөх, код давхцах асуудал үүсч байсан. Тухайлбал нэмэлт орлогын ангилал, тайлангийн ангилал, эх үүсвэрийн ангилал 2 зөрөх, код нь давхцах гэх мэт. Мөн бас нэг хүндрэл нь эдгээр ангиллыг батлахдаа тайлбарыг стандартчилж батлаагүй нь хэрэгжилтийн түвшинд хүндрэл учруулах талтай.

Тусгай сан:

ҮАГ-аас Засгийн газрын тусгай сангуудын үйл ажиллагааны ил тод байдлыг нэмэгдүүлэх шаардлагатай гэж зөвлөмж өгсний дагуу тус агуулгыг тусгайлан судалсан.

Төсвийн тухай хуулийн 18 дугаар зүйлээр тусгай санг зохицуулдаг. “Засгийн газрын тусгай сан” /цаашид “тусгай сан” гэх/ гэж Засгийн газрын тодорхой чиг үүрэг, зорилтыг санхүүжүүлэх зориулалттай **төсвийн тусгай данс**. Тусгай сангийн эрх зүйн үндэслэлийг тодорхойлогч үндсэн хуулиуд нь Төсвийн тухай, Засгийн газрын тусгай сангийн тухай хууль бөгөөд зарим сангуудын хувьд бие даасан тусгай хуулиар зохицуулагддаг. Тусгай сан нь Засгийн газрын тусгай сан, орон нутгийн тусгай сан гэсэн төрөлтэй.

Зураг 3. Тусгай сангийн ангилал, эрхзүйн зохицуулалт



- **Тусгай сангийн бүртгэл:**

Иргэний хуулийн 26 дугаар зүйлийн 26.3-т “Нийтийн эрх зүйн хуулийн этгээдийн иргэний эрх зүйн чадвар хуульд заасан журмаар байгуулагдсанаар үүсч, татан буугдсанаар дуусгавар болох бөгөөд иргэний эрх зүйн харилцаанд бусад оролцогчтой адил тэгш эрхтэй оролцоно” гэсний хүрээнд Засгийн газрын тусгай сангууд хамаарах тул Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.5-д “Энэ хуулийн 7.1.8, 7.1.9-д олон улсын байгууллага, Засгийн газрын тусгай сан, комисс, хороо, үндэсний зөвлөл хамаарахгүй бөгөөд улсын бүртгэлд бүртгэхгүй” гэсний дагуу Улсын бүртгэлд бүртгэгдээгүй байна.

Засгийн газрын тусгай сангийн хуулиар баталсан 23 сангийн 5-ийг нь бие даасан хуулиар зохицуулж, эдгээр хуулиуд болон холбогдох журмаар орон нутгийн түвшинд салбар нэгж байх асуудлыг шийдвэрлэдэг. Орон нутгийн тусгай санг байгуулах, түүний үйл ажиллагааны зарчим, хэрэгжүүлэх чиг үүрэг, уг сангийн орлого, түүний зарцуулалтын талаарх харилцааг Төсвийн тухай хуулиар зохицуулна гэж заасан боловч холбогдох зохицуулалт байхгүй. Мөн орон нутгийн хэдэн тусгай сан байдаг талаар мэдээлэл хангалтгүйн дээр, ялгаатай эрхзүйн актаар зохицуулагддаг байна. Сангийн яамны ЗГНСТайланд төсөл, сан хоёрыг нэгтгэж гаргадаг нь тухайн мэдээллийг ялгах боломжгүй болгосон.

- **Эх үүсвэрийн хувьд** Засгийн газрын тусгай сангийн тухай хуулиар заасан нийтлэг ангилал нь Сангийн яамны эх үүсвэрийн ангилалтай нийцүүлэх шаардлага байна. Улсын төсвөөс дараахь 2 төрлийн шилжүүлгийг олгож болно.
 - 4.1.2.“эргэн төлөгдөх зээл” гэж тодорхой хугацааны дараа төсөвт буцаан төвлөрүүлэх нөхцөлтэйгөөр олгож байгаа улсын төсвийн шилжүүлгийг;
 - 4.1.3.“эргэн төлөгдөх нөхцөлгүй олгосон эх үүсвэр” гэж урсгал зардал, хөрөнгийн зардлыг санхүүжүүлэх зориулалттай улсын төсвийн шилжүүлгийг.

Энэ нийтлэг ангиллаас гадна сан бүрийн өөрийн онцлогт тохирсон санхүүгийн эх үүсвэр, үйл ажиллагааны чиглэлтэй байгаа нь мэдээллийг бүтэцчилж стандартчилахад хүндрэлтэй байна. Жишээ нь эрүүл мэндийг дэмжих сан архи,

согтууруулах ундааны онцгой албан татварын 1%, эмийн импортын гаалийн болон НӨАТ-ын 2% гэх мэт эх үүсвэрийг заасан ч энэ санхүүжилтийг авч чаддаггүйн дээр улсын төсвөөс гэх нэгдсэн эх үүсвэрээр санхүүжилт хийгдэж байгаа нь ямар эх үүсвэрээс хэрхэн орсныг тодорхойлоход хүндрэлтэй байдаг.

Code	Сангийн яамны эх үүсвэрийн ангилал	6.1.Тусгай сан нь дараах нийтлэг эх үүсвэрээс бүрдэнэ
3	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	6.1.1.улсын төсвийн хөрөнгө; 6.2.1.эргэн төлөгдөх зээл; 6.2.2.эргэн төлөгдөх нөхцөлгүй олгосон эх үүсвэр. 6.1.2.хандив, тусламж; гадаад улс олон улсын байгууллага, гадаадын ААНБ дотоодын ААНБ иргэн. 6.1.3.тусгай сангийн өөрийн үйл ажиллагаанаас олсон орлого; Үндсэн үйл ажиллагаанаас олсон орлого Туслах үйл ажиллагаанаас олсон орлого хамаарна. 6.1.4.зээлийн хүүгийн орлого.
31	Улсын төсвөөс санхүүжих	
310001	Улсын төсвөөс санхүүжих	
310002	Засгийн газрын тусгай сангаас санхүүжих	
310003	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	
310004	ОНХНС-аас санхүүжих	
32	Орон нутгийн төсвөөс санхүүжих	
320001	Орон нутгийн төсвөөс	
320002	ОНХС-аас санхүүжих	
33	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	
330001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	
330002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	
34	Хүний хөгжил сангийн төсвөөс санхүүжих	
340001	Хүний хөгжил сангийн төсвөөс санхүүжих	
35	Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	
350004	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	
36	Тусламжийн эх үүсвэрээс санхүүжих	
360001	Тусламжийн эх үүсвэрээс санхүүжих	
37	Бусад эх үүсвэр	
370001	Төсөв болон дамжуулан зээлдүүлсэн зээлээс эргэж төлөгдөх	
370002	Хэмнэлтээр төсвийн санхүүжилт бууруулах	

- **Тусгай сангийн төсвийн тайлагнал:** Засгийн газрын тусгай сангийн ангилал нь хөтөлбөр, зориулалтаар ангилж байгаа бөгөөд хөтөлбөрийн хувьд 3 хүртэлх ангиллаар тайлагнаж байгаа нь сангийн үйл ажиллагаа ил тод байх нөхцөлийг хангаж чадахгүй байна.

- **Тусгай сангийн тайлагнал, ил тод байдал:**

Тусгай сангийн тухай хуулийн 24 дүгээр зүйлд тайлагнал, ил тод байдлыг зохицуулсан бөгөөд ТЕЗ нь хагас, бүтэн жилийн тайланг Сангийн яаманд хүргүүлнэ. Харин тусгай сангийн хөрөнгийн зарцуулалт, гүйцэтгэл, санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээний мэдээллийг холбогдох шийдвэрийн хамт тухайн шийдвэр гаргасан сард нь олон нийтэд ШДНЦХ болон байгууллагын цахим хуудсаар хуульд заасан хугацаан, хэлбэрээр тогтмол мэдээлнэ. Тусгай сангийн жилийн эцсийн зарцуулалтын тайланг аудитын дүгнэлтийн хамт уг тайлан гарснаас хойш 20 хоногийн дотор байгууллагын шилэн данс, цахим хуудсаар дамжуулан нийтэд мэдээлнэ.

Боловсролын зээлийн сан, Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан, Хөдөө аж ахуйг дэмжих сан шинээр олгох зээлийн эх үүсвэрийн хэмжээ, сонгон шалгаруулалтын журам, тавих шаардлага, бүрдүүлэх баримт бичгийн жагсаалтыг цахим хуудсаараа дамжуулан мэдээлж, мэдээллийг тогтмол шинэчилнэ.

Дээрх сангуудаас гадна Шинжлэх ухаан, технологийн сангаас зээл, буцалтгүй тусламж, санхүүгийн дэмжлэг авахаар хүсэлт ирүүлсэн иргэд, хуулийн этгээдийн бизнес төлөвлөгөөгөө танилцуулах, түүнийг сонгон шалгаруулах, үнэлэх үйл явцыг олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр нээлттэй, ил тод зохион байгуулна.

Зөвлөмж:

Хүчин төгөлдөр хуулийн заалт	Зөвлөмж
3.2.1.улс, орон нутгийн төсөв болон Нийгмийн даатгалын сангийн төсөв;	Монгол Улсын нэгдсэн төсөв түүний бүрэлдэхүүн төсөв; Эсхүл Улс, орон нутгийн төсөв;
3.2.2.орон нутгийн хөгжлийн сан;	Хэвээрээ
3.2.3.Засгийн газрын тусгай сан;	Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд заасан тусгай сан гэж өөрчлөн найруулах
3.2.4.төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах үйл ажиллагаа;	Хэвээрээ
3.2.5.Засгийн газар, орон нутгийн өрийн бичиг, санхүүгийн бусад хэрэгсэл;	Засгийн газар, орон нутгийн өр, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл гэж хуулийн 3.2.8 дахь заалттай уялдуулан нэгтгэх
3.2.6.Засгийн газар, орон нутгийн гадаад болон дотоод зээл, буцалтгүй тусламж;	Хэвээрээ
3.2.7.төр, хувийн хэвшлийн түншлэл, концесс;	Хэвээрээ

3.2.8.Засгийн газар, орон нутгийн баталгаа болон төсвийн өр, авлага үүсгэх аливаа бусад шийдвэр.	3.2.5-тай утга ижил тул нэгтгэн өөрчлөн найруулах, эсхүл өр, өрийн хэрэгслийг задлах /доор задалсан/
Нэмэх  Нэмсэн хэсгийг ОУ байгууллага төсвийн нэг хэсэг гэж үзэж санал өгсөн тул тусад нь бус нэгдсэн төсөв дээр нэмэх	Төсвийн орлого, зарлага, үр дүнгийн үзүүлэлт, мөнгөн гүйлгээ, зарцуулах аливаа шийдвэр, холбогдох гэрээ;
	Татаас, шилжүүлэг, хандив, тусламж;
	Санхүүгийн тайлан, аудитын дүгнэлт болон дүгнэлтийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ;


Үндэсний Аудитын газраас өгсөн зөвлөмж:

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.2.3-д Засгийн газрын тусгай сангийн “*төсөв санхүүгийн үйл ажиллагааны төлөвлөлт, гүйцэтгэл, хэрэгжилт, тайлагнал, эдгээртэй холбоотой мөнгөн болон бусад гүйлгээ*”. Засгийн газрын тусгай сангуудын төсвөөс зээл, хөнгөлөлт, урамшуулал олгох сонгон шалгаруулалтын үйл ажиллагааг ил тод мэдээлэх зохицуулалтыг холбогдох хууль тогтоомжтой уялдуулан Шилэн дансны тухай хууль, холбогдох журамд нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатайг харуулж байна.

Хуулийн 3 дугаар зүйлд заасан байгууллагууд мөнгөн дүнгийн хэмжээнээс үл хамааран бүх гүйлгээг шилэн дансаар мэдээлдэг болгох.

Засгийн газрын тусгай сангуудын төсөв санхүүгийн үйл ажиллагааг ил тод мэдээлэх зохицуулалтыг Шилэн дансны тухай хуультай уялдуулах талаар холбогдох арга хэмжээ авах.

Зураг 6. Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд мэдээлэл байршуулах байгууллагын төрөл, ангилал



Үүнд: Ерөнхий ангилал Дэд ангилал Нарийвчилсан ангилал

3.2.3. 3 дугаар зүйлийн 3.4 хэсгийн хэрэгжилтийн үнэлгээний талаар:

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.4 дэх хэсэгт “Төрийн нууцад хамаарахаас бусад төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, хэрэгжилт, тайлагналыг байгууллагын нууцад хамааруулан нийтэд мэдээлэхээс зайлсхийхийг хориглоно” гэсэн зохицуулалт нь мөн хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.4-т “хуулийн дагуу нууцад хамааруулснаас бусад бүх мэдээлэл нээлттэй байх” гэсэн зарчимд тулгуурласан байна.

Ялгаатай бизнесийн зарчмаар үйл ажиллагаа явуулдаг төрийн өмчит аж ахуйн нэгжийн зарим мэдээллийг ил тод байлгах нь өрсөлдөгчид мэдээллээ алдах эрсдэлтэй байгаа талаар санал, хүсэлт, гомдлыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт хүргүүлдэг байна.

Харин Үндэсний аудитын газраас дараахь зөвлөмжийг гаргасан байна.

Аудитын мэдээлэл	Эрх зүйн зөрчлийн агуулга	Зөвлөмжийн агуулга
Тайлангийн холбогдох линк:		http://www.audit.mn/
ҮАГ-НАГ/2015/ 04-НА кодтой аудитаар өгсөн зөвлөмж:	Банкны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2-т заасан Банк, түүний хараат болон охин компанид хориглох үйл ажиллагаатай нийцэхгүй, Байгууллагын нууцын тухай хууль, Хувь хүний нууцын тухай хуультай зөрчилдөх, бизнесийн өрсөлдөөнд сөргөөр нөлөөлөх нөхцөл байдал үүсгэж байна.	Хуулиар тусгайлсан зохицуулалттай байгууллагуудын мэдээлэх мэдээллийн агуулга, стандартыг Төрийн нууцын жагсаалт батлах тухай хууль, Банкны тухай хууль, Байгууллагын нууцын тухай хууль, Хувь хүний нууцын тухай хуультай нийцүүлэн шинэчилж, шилэн дансны цахим санд байршуулах эрх зүйн орчныг боловсронгуй болгох;
	Холбогдох хуулиар олгож буй нэг удаагийн урамшууллыг шилэн дансанд мэдээлэх эсэх нь Хувь хүний нууцын тухай хуультай зөрчилдөж байна.	Салбарын хуулийн дагуу ажилтнуудад олгож буй урамшууллыг мэдээлэх асуудлыг Хувь хүний нууцын тухай хуультай нийцүүлэн шинэчлэн боловсруулах;

Банкны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2-т “Банк, түүний харилцагч болон гуравдагч этгээд нууц гэж үзсэн аливаа мэдээллийг дор дурдсанаас бусад тохиолдолд бусдад гаргаж өгөх, задруулах, ашиглахыг банкны хувьцаа эзэмшигч, төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүн, гүйцэтгэх удирдлага, хянан шалгах зөвлөл, ажилтанд хориглоно” гэж заасан бөгөөд төрийн өмчийн банкны тухайд уг заалтын дагуу нууцлах үүрэгтэй мэдээллийг Шилэн дансны тухай хуулийн хүрээнд нээлттэй байршуулснаар Банкны тухай хууль хууль зөрчсөнд тооцогдох юм.

Хувь хүний нууцын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 3-т “хөрөнгийн нууцад зөвхөн эд хөрөнгө, оюуны өмч, эрхийн эзэн, эсхүл түүний итгэмжлэгдсэн хүмүүс мэдэх, түүнчлэн эрх бүхий байгууллага албан тушаалтны албан үүргийнхээ дагуу олж мэдсэн мэдээ, баримт бичиг, тоо, гэрээ хэлцэл, биет зүйлийг” гэж, 5 дугаар зүйлийн 4-т “Хувь хүний нууцыг хуулийн дагуу болон итгэмжлэлээр олж мэдсэн этгээд бусдад задруулахыг хориглоно” гэж тус тус

зааснаас үзвэл Шилэн дансны тухай хуулийн үйлчлэх хүрээн хамаарах байгууллага нь хувь хүний нууцад хамаарах мэдээллийг олон нийтэд мэдээлэх нь хориглогдсон байх боловч Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.4 дэх хэсгийн агуулгаар Төрийн нууцад хамаарахаас бусад мэдээллийг шилэн дансны цахим хуудаст байршуулах замаар мэдээлэхийг шаардсан нь зөрчилдөөнтэй байдлыг үүсгэж байна.

Иймээс Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэх явцад бодит байдалд байгууллага, хувь хүний нууцтай холбоотой хууль хоорондын зөрчил үүсч байгаа болох нь тогтоогдож байна.

Зөвлөмж:

Үндэсний аудитын газраас өгсөн дээрх зөвлөмжийн дагуу Хуулиар тусгайлсан зохицуулалттай байгууллагуудын үйл ажиллагааны онцлогийг харгалзан Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.4 дэх хэсгийг өөрчлөн найруулах замаар хууль хоорондын зөрчлийг арилгах нь зүйтэй байна.

3.2.4. 6 дугаар зүйлийн хэрэгжилтийн үнэлгээний талаар:

6 дугаар зүйл.Шилэн дансны мэдээлэл

Хуулийн үйлчлэх хүрээний ялгаатай байгууллагууд ялгаатай мэдээллийг байршуулахаар, бас байршуулж буй мэдээллийн тоо нь буюу ил тод байдал харилцан адилгүй байна.

Байгууллага	Байршуулах мэдээлэл /хуулийн заалтаар/
3.1.1.төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд;	39 төрлийн мэдээлэл
3.1.2.төрийн өмчит үйлдвэрийн газар;	
3.1.3.хяналтын багц (1/3) дээш нь төр, орон нутгийн өмчит компани;	9 төрлийн мэдээлэл
Санхүү төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага	52 төрлийн мэдээлэл
3.1.4.ААНБ	3 төрлийн мэдээлэл
3.1.5.ААНБ, иргэн	
Шилэн дансанд мэдээлэл оруулдаг байгууллага мэдээллийн төрлөөр Хавсралт-2 дахь хүснэгтээс дэлгэрэнгүйг харна уу.	Хавсралт-2 

Шилэн дансны мэдээллийн зохицуулалтын хэрэгжилтийг практикт нийцэж байгаа байдал болон хүлээн зөвшөөрөгдсөн байдлын шалгуур үзүүлэлтээр үнэлэхдээ хууль тогтоомж хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш хуулиар тогтоосон мэдээллийг хугацаанд, бүрэн гүйцэд байршуулах үүргээ биелүүлсэн эсэхийг жил бүрийн аудитын нийцлийн тайланд үндэслэн тогтоов.

Шилэн дансны тухай хуульд заасны дагуу төсвийн удирдлагыг хэрэгжүүлсэн шийдвэр, үйл ажиллагааны ил тод байдлыг улсын төсвийн ерөнхийлөн захирагчид болон тэдгээрт хамаарах байгууллагууд 2018 онд 90.2 хувь, 2019 онд 91.5 хувь, аймаг, нийслэлийн төсвийн төсвийн ерөнхийлөн захирагчид болон тэдгээрт хамаарах байгууллагууд 2018 онд 89.3 хувь, 2019 онд 87.9 хувь хэрэгжүүлж ажилласан Үндэсний аудитын газраас үнэлсэн байна.

Үүнээс дүгнэн үзвэл хууль хэрэгжүүлэгчийн зүгээс хангалттай бус хэмжээнд хуулийн хэрэгжилтийг хангуулдаг болох нь тогтоогдож байна. Үүний шалтгааныг хууль хэрэгжүүлэх явцад гаргаж буй зөрчилд оногдуулах хариуцлагын тогтолцоог бүрэн хуульчилж өгөөгүйтэй холбон тайлбарласан Үндэсний аудитын газрын дүгнэлт, зөвлөмжөөр удаа дараа гаргаж байсан байна. Мөн түүнчлэн шилэн дансанд байршуулах мэдээллүүд нь давхцалтай буюу нэг мэдээллийг хэд хэдэн удаа байршуулахаар хуульд заасан нь ажлын ачааллыг нэмэгдүүлсэн үр ашиггүй байдлыг бий болгодог байна.

Мэдээллийн ил тод байдалтай холбоотой хэд хэдэн хууль, журам байгаагаас гадна бусад цахим хуудсаар давхар мэдээлж байгаа нь давхцал үүсгэж ажлын ачаалал бий болгож байна. Зарим цахим хуудасны мэдээлэл нь агуулгын хувьд төстэй ч иж бүрэн бус байгаа нь шууд ШДНЦХ-тай холбох шаардлагыг хангахгүй байна.

Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулиар ил тод байлгах /цахим хуудас болон самбар/	Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн Шилэн дансны хуультай давхацсан агуулга бүхий заалтууд
6.1.1.үйл ажиллагааны ил тод байдал;	7.1.7. төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлж буй бол нэр, хаяг, цахим хуудас, эрхэлж байгаа үйл ажиллагааны чиглэл 7.1.9. улсын төсөв, гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт, явц, байдлын талаар
6.1.2.хүний нөөцийн ил тод байдал;	Шилэн дансны тухай хуулиар орон тооны мэдээллийг байршуулахыг шаарддаг.
6.1.3.төсөв, санхүүгийн ил тод байдал;	Шилэн дансны тухай хуулиар зохицуулна гэж заасан хэдий ч журмаар дараах нэмэлт мэдээлэл гаргана гэж заасан. Хавсралт-7 дахь Журмыг харна уу. . 7.1.1. Худалдан авалтын төлөвлөгөө; 7.1.2. Хөрөнгө оруулалтын дэлгэрэнгүй мэдээлэл; 7.1.3. Богино болон урт хугацааны зээл, татаас; 7.1.4. Халамжийн зардал; 7.1.5. Дотоод аудитын үнэлгээ; 7.1.6. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд болон шинээр ажилд орсон албан хаагчийн талаар; 7.1.7. Удирдлагуудын гадаад томилолтын талаархи мэдээлэл томилолт бүрээр;
6.1.4.төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны ил тод байдал.	

	7.1.8. Байгууллагын зардлаар суралцагчдын мэдээлэл.
ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 4.1.2. 50 буюу түүнээс дээш хувийн төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээд захиалагч байна;	Энэ хуулийн дагуу СЯ-ны ХАА тайлан болон ХАА цахим хуудсанд эдгээр байгууллагууд мэдээллээ байршуулдаг.

Шилэн дансны тухай хуулийн 6.7-д “Нийгмийн даатгалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв болон бусад төрийн захиргааны байгууллага нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авах эрх бүхий этгээдийн жагсаалтыг тухайн этгээдийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэрийн хамт **цахим хуудсанд** байрлуулан тухай бүр шинэчилж мэдээлнэ.” гэж өөрийн цахим хуудсанд мэдээлэхээр заасан тул мэдээлэлтэй танилцах, хяналт тавихад хүндрэлтэй бөгөөд Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд мэдээлэхээр зохицуулах шаардлагатай.

Хуулийн 6.10-д “Шилэн дансны мэдээлэл, зарлагын гүйлгээ бүрд түүнд холбогдох эрх бүхий этгээдийн **шийдвэрийн эх хуулбар**, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан **мэдэгдлийг** хавсаргасан байна.” Гэж заасны дагуу бүх төрлийн гүйлгээ хийх тохиолдолд шийдвэрийн эх хуулбар, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилго бүхий мэдэгдлийг хавсарган байршуулах нь байршуулах нь ач холбогдолгүй бөгөөд ажлын болон системийн ачааллыг нэмэгдүүлдэг байна.

Зөвлөмж-1:

- Төсвийн байгууллага, төсөл хөтөлбөр, Засгийн газрын тусгай сангийн байршуулах мэдээлэл ижилхэн байх. Журмаар онцлогийг харгалзсан маягттай байх.
- Санхүү төсвийн асуудал эрхэлсэн, төрийн захиргааны төв байгууллагын байршуулах мэдээллийг байгууллагын түвшний мэдээллээс салгах.
- Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдүүдийг үйлдвэр болон компани гэдгээс үл хамааран ижил төрлийн мэдээлэл байршуулах. Цаглабарын хувьд 3.1 ангиллаас ялгаатай байдаг тул тусад нь гаргах.
- Хувийн хэвшлийн болон гэрээгээр гүйцэтгэгч байгууллагын мэдээллийг төвлөрсөн байдлаар харьяа байгууллагууд нь байршуулахаар зохицуулах. Учир нь тус мэдээллийг гүйцэтгэгч талаас илүүтэй захиалагч тал иж бүрнээр байршуулах боломжтой.
- Шилэн дансны хуулиар ил тод болгож байгаа мэдээллийг зохицуулах, бөгөөд эдгээрийг зөвхөн ШДНЦХ-аар бус бусад системүүдээр ил тод болгож байх, уян хатан бүтэцтэй байх. Жишээ нь аудитын дүгнэлт бүхий тайланг ил болгох нь зөв бөгөөд энэ мэдээллийг ҮАГ өөрийн системээр тайлагнаж байх. Үүний адил НДС, ЭМДС өөрсдийн мэдээллийг хариуцах.
- Мэдээллийн цаглабарыг Шилэн дансны хуулиар зохицуулах шаардлагатай эсэх, төсвийн тухай хууль, аудитын хуулийн цаглабар болон бусад хугацааг журмаар зохицуулж болох эсэх.

- Нэршил, тайлбар нь бусад эрх зүйн бичиг баримттай зөрчилдсөн болон найруулга зүйг засварлах шаардлагатай мэдээлэл байна.
- Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдлийг зарлагын гүйлгээ бүрт гаргасан мэдэгдлийг ШДНЦХ-т байршуулах нь ач холбогдолгүй бөгөөд ажлын болон системийн ачааллыг нэмэгдүүлдэг тул ашиг сонирхлын зөрчил үүссэн талаарх болон эрх бүхий этгээдийн шийдвэрийг мэдээлэх нь зүйтэй.
- Концессын асуудал нь хуулийн холбогдох өөрчлөлтөөр Сангийн сайд, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дарга, Шадар сайд гэх зэрэг төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудалд шилжиж ирсэн тул хуулийн 6.5 дахь хэсгээр зөвхөн Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад харьяалуулан мэдээлэл байршуулахаар заасан нь учир дутагдалтай болжээ. Мөн өнөөдрийн бодит байдалд Үндэсний хөгжлийн газар концессын асуудлыг хариуцаж, шилэн дансны нэгдсэн цахим хуудаст мэдээлдэг тул Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын мэдээлэх зохицуулалт нь оновчгүй болсон.

Нэмсэн	Зарчмын өөрчлөлт	Хасах
• Улс, орон нутгийн ТЕЗ-ийн байршуулах мэдээлэл хуулиар заагаагүй боловч журмаар нэмдэг. Хуульд тусгасан. • Хөтөлбөр, зориулалт, эдийн засгийн ангиллаар тайлагнадаг иж бүрэн болгох • Нэмэлт төсөв • Төсвийн орлого, зарлагын гүр дүн • Дансны дугаар • Сургалт, мэдээлэл аргазүйг нэмэх, тайлагнал, хариуцлага урамшууллын хэсгийг баяжуулах¹¹.	• ТБОНӨ компани, ТӨҮГ ижил мэдээлэл байршуулах • Төсвийн байгууллага, гадаадын зээл тусламж, тусгай зориулалтын сан ижил мэдээлэл • Хуулиар ил тод байлгах мэдээллийн жагсаалтыг гаргана. Байршуулахдаа ШДНЦХ-д эрхлэх асуудлын байгууллагын бие даасан системийг холбож болно.	• 6.10. Шилэн дансны мэдээлэл, зарлагын гүйлгээ бүрд түүнд холбогдох эрх бүхий этгээдийн шийдвэрийн эх хуулбар - Анхан шатны санхүүгийн баримт • 6.10. Ашиг сонирхолгүйн мэдэгдэл – хувь хүний нууцтай холбоотой • ТБОНӨ хуулийн этгээд гүйлгээний мэдээлэл байршуулахгүй байх. • Нэг ижил төрлийн гэрээ /ерөнхий загвар, жагсаалт/ • Төсөвтэй шууд холбоогүй • Хувь хүний гачигдал

Зөвлөмж-2: (хуулийн заалт тус бүрээр)

Шилэн дансны тухай хуульд заасан мэдээлэл /сайжруулах саналтай заалтыг оруулсан/	Найруулга / Анхаарах	Хүндрэл
6.1.ШД хуулийн 3.1.1, 3.1.2-т байгууллага, албан тушаалтан тогтмол мэдээлэх мэдээлэл:		

¹¹ Оруулах саналыг журмын төслөө. с харж болно

6.1.1.тухайн жилийн төсөв, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлтийг жил бүрийн 01 дүгээр сарын 10-ны өдрийн дотор;	"ТБОНӨҮГ хувьд тус хугацаанд гарах боломжгүй байдаг. ТУЗ-аар баталдаг. 3 сарын 30. Мэдээлэл жилийн турш өөрчлөгддөг бөгөөд , ялангуяа арга нь нэг удаа байршуулах нь зохимжгүй." Худалдан авалтын төлөвлөгөөг төрийн байгууллага, албан газар 1 сар 10, ТБОНӨҮГ - нь 1 сар 10-д төслийг, ТУЗ-аар батлагдсанаас хойш 7 хоногийн дотор, нэмэлт өөрчлөлт орвол хаана ямар нэмэлт, өөрчлөлт орсон тайлбарын хамт тухай бүр байршуулна.	Хугацаа
6.1.3.дараа жилийн төсвийн төслийг жил бүрийн 09 дүгээр сарын 15-ны өдрийн дотор;	СЯ-ны төсвийн төлөвлөлтийн FISCAL системээс нэгдсэн байдлаар байршуулах тул УТ хувьд 9 сар 20, ОН төсвийн хувьд суурь орлого, суурь зарлагыг төсөл гэж авч үзэн 11 сар 20 тус дүнгээр гарна.	Хугацаа
6.1.6.төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбарыг улирал бүр.	Төсвийн тухай хуулиар хэтрэлт /төсвийн байгууллагад гардаггүй/, хэмнэлт гэдэг нь одоогийн зохицуулалтаас өөр утгатай бөгөөд жилийн эцэст гардаг. Эсвэл төлөвлөгөө, гүйцэтгэл түүний зөрүү гэж өөрчлөх. 6.1.6. болон 6.3.3 төсвийн хэмнэлт, хэтрэлтийг холбогдох шалтгаан тайлбарын хамт жилийн эцэст эсхүл төлөвлөгөө, гүйцэтгэл түүний зөрүүний тайлбарыг улирал бүр (ШДНЦХ дээр сар бүр байрлуулдаг) гэж өөрчлөх .	Нэршил, тайлбар
6.2.Энэ хуулийн 6.1.1-д /төсвийн төлөвлөлт/ дараах байдлаар илэрхийлэгдсэн байна:		
6.2.1.эрх бүхий байгууллагаас баталсан жилийн төсөв, гүйцэтгэлийг хэмжих шалгуур үзүүлэлт; 6.3.1.Төсвийн ерөнхийлөн захирагчийн энэ хуулийн 6.2.1-д тодорхойлсон үзүүлэлт, хүрсэн үр дүн, хэрэгжилтийг хэмжих тоон болон чанарын үзүүлэлт;	Журмын маягтаар бол ТЕЗ хүрэх үр дүнгийн үзүүлэлтийг тайлагнадаг. Үүнтэй холбоотой нэмэлт маягт санал болгосон.	Нэршил, тайлбар

6.2.2.орлого /үндсэн үйл ажиллагааны орлого, төсөвт байгууллагын өөрийн орлого/; 6.2.6.зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр /улсын төсөв, орон нутгийн төсөв, өөрийн орлого/.	Адилхан эх үүсвэрийг илэрхийлсэн 6.2.2 болон 6.2.6 6.2.2-6.2.6. Санхүү төсвийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагаас баталсан төсвийн ангилал болон нягтлан бодох бүртгэлийн стандарт, тайлангийн ангиллуудыг мөрдлөг болгоно. Төсвийн ангилал - Орлогын эдийн засгийн ангилал - Зардлын эдийн засгийн ангилал	Нэршил, тайлбар
6.2.3.урсгал зардал /цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэл, бусад урсгал зардал, хөрөнгийн зардал, татаас шилжүүлэг/; 6.2.4.хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, концессын зүйлийн жагсаалт; 6.2.5.улсын төсөв болон орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлого, тэдгээрийн задаргаа;	- Төсвийн зарлагын хөтөлбөрийн ангилал - Зардлын зориулалт болон арга хэмжээний ангилал - Эх үүсвэрийн эдийн засгийн ангилал	
6.3.Хуулийн 6.1.2-т /хагас, бүтэн жилийн гүйцэтгэл/ дараах байдлаар илэрхийлэгдэнэ:		
6.3.3.төсөв хэмнэсэн болон хэтэрсэн бол холбогдох шалтгааныг тайлбарласан тайлбар;	төсвийн тухай хуулиар "нэмэлт орлого" нэр томъёо хэрэглэдэг. Хэтрэлт гэдэг үг байдаггүй бөгөөд зөрүүтэй байдал гэх.	Нэршил, тайлбар
6.3.4.өмнөх оны төсвийн зарлагын хэмнэлт, туслах үйл ажиллагааны орлогын давсан хэсгийг урамшуулалд зарцуулсан бол зориулалтыг заасан байх;	6.3.4.төсвийн зарлагын хэмнэлт болон бусад нэмэлт орлогын эх үүсвэр, зарцуулалтын зориулалтыг холбогдох шийдвэр, тайлбарын хамт; 6.4.2.тухайн байгууллагын хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зориулалтын үйлчилгээний хөлсний хэмжээнд орсон өөрчлөлт; 6.4.6.худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт шалгалтын дүн; /ХАА аудитыг хамтад нь хийдэг/	
6.3.5.хандив, тусламжийн хэмжээ, түүний зарцуулалт;	Материаллаг болон мөнгөн хандив, тусламж....	Нэршил, тайлбар
6.3.6.хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээг тендер зарлаж, сонгон	6.3.6. болон 6.4.3. дахь заалтыг нэгтгэх, www.e-tender.mn д хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн	Нэршил, тайлбар

шалгаруулсан бол шалгаруулалтын ерөнхий мэдээлэл; 6.4.3.тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилга, тендерт оролцохыг сонирхогчид тавих шалгуур үзүүлэлт, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгаан;	баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилга, оролцохыг сонирхогчид тавих шалгуур үзүүлэлт, шалгаруулалтын ерөнхий мэдээлэл, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгааны талаарх мэдээлэл бүхий ХАА-ны системийг холбох ;	
6.3.8.тусгай сангийн орлого, зарлага, хөрөнгө оруулалт;	Хасах. Байршуулах субъектээрээ орсон байгаа	
6.3.9.орон нутгийн хөгжлийн сангийн гүйцэтгэл.	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн төлөвлөгөө, гүйцэтгэл, үр дүнгийн ОНХС нэгдсэн системтэй холбож түгээнэ.	
6.4.Энэ хуулийн 3.1.1 /төр/ , 3.1.2 /ТБОНӨ/-т заасан байгууллага долоо хоногийн дотор мэдээлэх мэдээлэл:		
6.4.4.таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг;.	6.4 нь гүйцэтгэл дотроо байвал. Хугацааны хувьд л ялгаатай. 6.4.4.таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг;. Данс байршдаг байгууллагын хувьд автоматжуулах боломжтой. Байршдаггүй нь одооны журмаар явна. 5 саяыг	Байршуулахад төвөгтэй мэдээлэл,
6.4.5.цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр;	6.4.5. Төрийн сан дээр данстай бол цалин, хөлс болон нэмэгдэл урамшил, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл, урсгал шилжүүлэг болон нууцын байгууллагын гүйлгээнээс бусад мэдээлэл хамаарна. ТБОНӨ хувьд орлого, зарлага, үр дүнгийн тайланг сар бүр гаргана.;	
6.4.6.худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт	ХАА тусгайлан аудит хийдэггүй. Аудит тайлангаа өөрийн системээр тайлагнадаг.	


болон бусад хяналт шалгалтын дүн		
6.4.8.бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс,төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр;	6.4.8.бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр; төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, холбогдох шийдвэр;	
6.5.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага энэ хуулийн 6.1, 6.4-т заасан мэдээллээс гадна дараах мэдээллийг гаргана:		
6.5.1.улсын төсөв, Нийгмийн даатгалын сангийн төсвийн орлого, зарлага, хөрөнгө оруулалт, төсвийн нэгдсэн үзүүлэлтийг хагас жилийн байдлаар тухайн жилийн 07 дугаар сарын 15-ны өдрийн дотор, жилийн эцсийн байдлаар дараа жилийн 01 дүгээр сарын 15-ны өдрийн дотор; 6.5.5.нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээг сар бүрийн 15-ны өдрийн дотор; 6.5.4.улсын төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбарыг улирал бүр;	5. Монгол Улсын нэгдсэн төсвийн төлөвлөгөө, гүйцэтгэл, тайлбарын хамт сар бүрийн 15-ны өдрийн дотор өссөн дүнгээр;	Агуулга давхацсан
6.5.1. Нийгмийн даатгалын сангийн төсвийн орлого, зарлага, хөрөнгө оруулалт, төсвийн нэгдсэн үзүүлэлтийг 6.7.Нийгмийн даатгалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв болон бусад төрийн захиргааны байгууллага нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авах эрх бүхий этгээдийн жагсаалтыг тухайн этгээдийн эцэг /эх/-ийн нэр,	Нийгмийн даатгалын сангийн орлого, зарлага, үр дүнгийн үзүүлэлтийг нэгдсэн болон аймаг нийслэлийн түвшинд задалж харуулах. НДС хариуцна. Мөн адил ЭМД. 6.7 Заалтыг өөрсдөө мэдээлэхээр журамласан. Гэхдээ ач холбогдол бага. - Хасах	Иж бүрэн болгосон

өөрийн нэрийн хамт цахим хуудсанд байрлуулан тухай бүр шинэчилж мэдээлнэ.		
6.5.2.Засгийн газрын гадаад зээл, тусламжийн ашиглалтын мэдээг улирал бүр;	6.5.2.Засгийн газрын гадаад зээл, тусламж, тэдгээрийн ашиглалтын мэдээг төсөл хөтөлбөр, санхүүжүүлэгч байгууллагаар улирал бүр;	Иж бүрэн болгосон
6.5.3.Засгийн газрын гадаад, дотоод өрийн мэдээллийг улирал бүр; 6.5.7.төсвийн алдагдлыг санхүүжүүлэх зорилгоор гаргасан Засгийн газрын дотоод үнэт цаасны мэдээллийг улирал бүр. 6.5.11.хөрөнгө оруулалтыг санхүүжүүлэх зорилгоор гаргасан Засгийн газрын гадаад үнэт цаасны мэдээллийг улирал бүр;	6.5.3.Засгийн газрын гадаад, дотоод өрийн бүтэц, өрийн зориулалт, төлбөрийн мэдээлэл улирал бүр;	Агуулга давхацсан
6.5.9.концессын гэрээ болон түүнд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг гэрээ байгуулагдсанаас нь хойш долоо хоногийн дотор; 6.5.10.концессын гэрээ байгуулсан тухай бүрд концесс эзэмшигч, түүний байгууллагын нууцад хамаарахаас бусад мэдээлэл, концессын зүйл, гүйцэтгэх ажил, үзүүлэх үйлчилгээний талаарх мэдээллийг долоо хоногийн дотор;	- Концессын асуудал нь хуулийн холбогдох өөрчлөлтөөр Сангийн сайд, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дарга, Шадар сайд гэх зэрэг төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудалд шилжиж ирсэн тул уг асуудлыг хариуцсан байгууллага мэдээлэхээр өөрчлөх шаардлагатай байна. - Заалтуудыг нэгтгэх: 6.5.9 болон 6.5.10-ийг концессын гэрээ байгуулах тухай бүрд концесс эзэмшигч, түүний байгууллагын нууцад хамаарахаас бусад мэдээлэл, концессын зүйл, гүйцэтгэх ажил, үзүүлэх үйлчилгээний талаарх мэдээлэл болон гэрээ болон концессийн дээр дурдсан мэдээлэлд нэмэлт өөрчлөлт орвол долоо хоногийн дотор. Үндэсний хөрөнгө оруулалтын газар нь ШДНЦХ байршуулна.	Агуулга давхацсан, Зохицуулалт оновчгүй


6.8.Хуулийн 3.1.3-т /хяналтын багц/ байгууллага долоо хоногийн дотор мэдээлэх мэдээлэл:		
6.8.1.тухайн байгууллагад холбогдох энэ хуулийн 3.2.5, 3.2.7, 3.2.8-д заасан шийдвэр; • 3.2.5.Засгийн газар, орон нутгийн өрийн бичиг, санхүүгийн бусад хэрэгсэл; • 3.2.7.төр, хувийн хэвшлийн түншлэл, концесс; • 3.2.8.Засгийн газар, орон нутгийн баталгаа болон төсвийн өр, авлага үүсгэх аливаа бусад шийдвэр. 6.8.2.худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилга, тендерт оролцохыг сонирхогчдод тавих шалгуур үзүүлэлт, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгаан; 6.8.3.төр болон орон нутаг тавь буюу түүнээс дээш хувийг эзэмшиж байгаа компанийн гаргасан их хэмжээний хэлцэлд тооцогдохуйц баталгаа, батлан даалт.	6.8.1.тухайн байгууллагад холбогдох энэ хуулийн 3.2.5, 3.2.7, 3.2.8-д заасан мэдээллийн дэлгэрэнгүй, холбогдох шийдвэр 6.8.2.худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, гүйцэтгэл тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилга, тендерт оролцохыг сонирхогчдод тавих шалгуур үзүүлэлт, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгаан; 6.8.3. Хяналтын багц биш өмчийн эзэмшлийн хувиар илэрхийлсэн нь зөрчилтэй. САНАЛ: Гүйлгээнээс бусад мэдээллийг байршуулахаар мөн бүх төрийн болон орон нутгийн өмчит ижил мэдээлэл байршуулахаар агуулгыг тодорхойлсон. Зөвхөн зарцуулалт төдийгүй орлогыг авч үзсэн. Заавар баримт бичгийг харна уу.	
6.10.Шилэн дансны мэдээлэл, зарлагын гүйлгээ бүрд түүнд холбогдох эрх бүхий этгээдийн шийдвэрийн эх хуулбар, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд	Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдлийг гаргах хуулийн зохицуулалт хэрэгжилт хангалтгүй байдаг бөгөөд зарлагын гүйлгээ бүрт гаргасан мэдэгдэлийг ШДНЦХ-т байршуулах нь ач холбогдолгүй, ажлын болон системийн ачааллыг нэмэгдүүлдэг тул ашиг сонирхлын зөрчил	Хэрэгжилт үр дүнгүй, оновчгүй зохицуулалт

заасан мэдэгдлийг хавсаргасан байна.	үүссэн талаарх болон эрх бүхий этгээдийн шийдвэрийг мэдээлэх нь зүйтэй.	
Хуулийн 3.1.4, 3.1.5-д заасан этгээдийн байршуулах мэдээлэл		
	Гүйцэтгэгч тал нь өөрийн сувгаар мэдээллийг хүргэх. Харин ШДНЦХ дээр захиалагч тал байршуулна. ТХХТ хэсэгт	

Зураг 4. Байгууллагын байршуулах мэдээллийн тойм бүдүүвч



Зураг 5. Сангийн яамны оруулах мэдээлэл, хар зураг



Үндэсний Аудитын газраас өгсөн Дүгнэлт, Зөвлөмж:

Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-д хамаарах Хүмүүнлэгийн болон буцалтгүй тусламж, хөнгөлөлттэй зээл хэлбэрээр санхүүждэг зарим томоохон төсөл, хөтөлбөрүүдийн хувьд санхүүжүүлэгч байгууллагаас гүйцэтгэгч хуулийн этгээдэд зарим санхүүжилтийг шууд шилжүүлдгээс тухайн төсөл, хөтөлбөрийн төсвийн зарцуулалт, гүйцэтгэлийн мэдээлэл бүрэн мэдээлэгдэхгүй байгаа нь хуулийн 4 дүгээр зүйлд заасан “мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх” зарчим хангагдахгүй байна.

Хүмүүнлэгийн болон буцалтгүй тусламж, хөнгөлөлттэй зээл хэлбэрээр санхүүждэг зарим томоохон төсөл, хөтөлбөр болон Засгийн газрын тусгай сангийн төсөв зарцуулах үйл ажиллагааг ил тод мэдээлэх талаар хууль, эрх зүйн орчныг сайжруулах шаардлагатай байна.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.2.3-т Засгийн газрын тусгай сангийн “төсөв санхүүгийн үйл ажиллагааны төлөвлөлт, гүйцэтгэл, хэрэгжилт, тайлагнал, эдгээртэй холбоотой мөнгөн болон бусад гүйлгээ” хуулийн үйлчлэлд хамаарах ерөнхий зохицуулалтыг тусгасан. Иймд Засгийн газрын тусгай сангийн төсвөөс зээл, хөнгөлөлт, урамшуулал олгох сонгон шалгаруулалтын үйл ажиллагааг ил тод мэдээлэх зохицуулалтыг холбогдох хууль тогтоомжтой уялдуулан Шилэн дансны тухай хууль, журамд нэмж тусгах шаардлагатай.

Мөн тайланд зөрчилтэй асуудлыг дурдсан Засгийн газрын тусгай сангуудын төсөв санхүүгийн үйл ажиллагааг ил тод мэдээлэх зохицуулалтыг Шилэн дансны тухай хуультай уялдуулах талаар холбогдох арга хэмжээ авах;

Хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4, 6.5-д заасан заалтыг давхардуулан зохицуулсан;

Банкны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2-т заасан Банк, түүний хараат болон охин компанид хориглох үйл ажиллагаатай нийцэхгүй, Байгууллагын нууцын тухай хууль, Хувь хүний нууцын тухай хуультай зөрчилдөх, бизнесийн өрсөлдөөнд сөргөөр нөлөөлөх нөхцөл байдал үүсгэж байна. Хуулиар тусгайлсан зохицуулалттай байгууллагуудын мэдээлэх мэдээллийн агуулга, стандартыг Төрийн нууцын жагсаалт батлах тухай хууль, Банкны тухай хууль, Байгууллагын нууцын тухай хууль, Хувь хүний нууцын тухай хуультай нийцүүлэн шинэчилж, шилэн дансны цахим санд байршуулах эрх зүйн орчныг боловсронгуй болгох;

Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-д заасан төсөл, хөтөлбөр, 3.1.2-т заасан ТӨҮГ харьяалах дээд байгууллага нь ТӨҮГ, төсөл хөтөлбөрийн төсөв, шалгуур үзүүлэлт, хүрэх үр дүнг дэлгэрэнгүйгээр батлах, түүнийг мэдээлэх эрх зүйн зохицуулалтыг бий болгох;

Салбарын хуулийн дагуу ажилтнуудад олгож буй нэг удаагийн урамшууллыг мэдээлэх асуудлыг хувь хүний нууцын тухай хуультай нийцүүлэн шинэчлэн боловсруулах;

Судалгааны ажлын дүгнэлт:

1. ШДНЦХ-д байршуулах мэдээллийн хамрах хүрээ (хуулийн 3.2 болон 6 дугаар зүйл) нь 3.1-т заасан байгууллагын байршуулах мэдээллээс өргөн хүрээг хамарсан. Өөрөөр хэлбэл Монгол Улсын нэгдсэн төсөв, Засгийн газрын нэгдсэн тайланд хамрагдах байгууллагын төсөв, санхүүгийн мэдээлэл, тэдгээрт хамрагддаг байгууллагаас гадна Засгийн газрын нэгдсэн тайланд хамрагддаггүй хувийн хэвшлийг хамруулсан нь төсөв, санхүүгийн нэгдсэн мэдээллээс зөрүүтэйн дээр мэдээллийг бүрэн гүйцэт, үнэн зөв оруулсан эсэхэд хяналт тавихад хүндрэлтэй байна. Тухайлбал Төрийн болон орон нутгийн өмч, хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, Засгийн газрын санхүүгийн нэгдсэн тайланд Төрийн болон орон нутгийн өмч, тэдгээрийн оролцоо нь 50 болон түүнээс дээш хувь бүхий байгууллагыг хамруулдаг бол Шилэн дансны тухай хуулиар 3.1.3-д хяналтын багцаар зохицуулж байна.

2. Төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн талаар төрөөс баримтлах бодлогыг тодорхойлж түүнд нийцүүлэн Шилэн дансны тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийг шинэчлэн сайжруулах шаардлагатай байна.

3. Зарим хууль, журмын заалт, нэр томьёо нь тодорхой бус байгаа нь ялгаатай ойлголтыг төрүүлж, харилцан адилгүй хэрэгжиж байна. Жишээлбэл, төсөв, өмч хөрөнгө зарцуулсан аливаа шийдвэр хэт ерөнхий байгаа тул зарим байгууллагын хувьд анхан шатны баримтыг байршуулж ачаалал үүсгэж байна. 6.1.6, 6.3.3 болон 6.3.4 дэх заалт төсвийн хэтрэлт, хэмнэлт, тэдгээрийн шалтгаан тайлбар нь Төсвийн тухай хуулийн ойлголтоос өөр хэрэгждэг. Мөн 6.2.2-т заасан орлого болон 6.2.6-т зааснууд нь аль аль нь зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг илэрхийлнэ гэх мэт давхардалтай, нэр томьёо, ойлголтын зөрүүтэй заалтууд байна.

4. Тоон мэдээллийн ашиглалт иргэн төвтэй гэхээс илүүтэй хяналт талд нь илүү анхаарснаас “төсөв, санхүү”-тэй холбоотой анхдагч буюу нэн шаардлагатай мэдээллээс илүүтэй бусад хоёрдогч, гуравдагч түвшний нэмэлт, хавсарга чанартай мэдээллийг оруулахаар хууль, журмаар зохицуулсан нь ач холбогдол багатай бөгөөд зарим төсөв, санхүүгийн мэдээлэл иж бүрэн бус, ил тод бус хэвээр байсаар байна. Жишээлбэл, тусгай сангуудын зарцуулалтын мэдээлэл хангалттай ил тод бус, 6.4.3-т тендерийн баримт бичиг тэдгээртэй холбоотой материал, 6.10эрх бүхий этгээдийн шийдвэрийн эх хуулбар, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдэл зэрэг нь төсөв санхүүтэй холбоотой анхдагч бус, процессийн шинж чанартай мэдээлэл.

5. ШДНЦХ-аар ил тод байлгаж байгаа мэдээллийн хувьд бусад байгууллагын үйл ажиллагаа, системтэй давхцаж байна. Тухайлбал, ШДНЦХ-д байршуулахаар шаардсан худалдан авалт, тендерийн мэдээлэл Худалдан авах ажиллагааны газрын www.e-tender.mn, төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой

хувьцаат компаниудыг Санхүүгийн зохицуулах хорооны журмаар зохицуулж Монголын хөрөнгийн биржийн <http://mse.mn/> цахим хуудсаар, ҮАГ-ын цахим хуудсаар аудитын дүгнэлт, тайлан нийтэд ил тод болгож байгаа нь давхцал үүсгэж байна.

3.2.5. 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсгийн хэрэгжилтийн үнэлгээний талаар:

8 дугаар зүйл.Хуулийн хэрэгжилтэд тавих хяналт

8.2.Энэ хуулийн 3.1.1-д заасан төсвийн байгууллага, албан тушаалтны шилэн дансны үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлд заасны дагуу төсвийн ерөнхийлөн захирагч хэрэгжүүлнэ.

8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсгийн хэрэгжилтийн үнэлгээг практикт нийцэж байгаа байдлаар үнэлж дүгнэн хууль тогтоомж хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш хангалттай бүрэн гүйцэд хэрэгжсэн эсэхэд үнэлгээ хийв.

Үндэсний аудитын газраас өгсөн зөвлөмжөөр Шилэн дансны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2-т ТЕЗ-ийн дотоод хяналтыг зөвхөн энэ хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-т заасан байгууллагад хуульчилсан нь Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1, 69.3 -т нийцэхгүй гэж дүгнэсэн байдаг.

Үүнийг харьцуулан бодитой эсэхийг судлан үзвэл.

Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1-д “Төсвийн ерөнхийлөн захирагч бүр хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, төсвийн хөрөнгө, өр, төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт, шалгалт хийх, үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж гаргах, эрсдэлийн удирдлагаар хангахад чиглэсэн дотоод аудитын албыг байгуулж, дотоод аудитор ажиллуулна.” гэж, 69.3-т “Дотоод аудитад төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмч давамгайлсан хуулийн этгээдийн санхүүгийн үйл ажиллагааг хамаарна” гэж тус тус заажээ.

Хуулийн 3.1.3-т хамаарах хяналтын багц буюу түүнээс дээш хэмжээний хувьцааг нь төр, орон нутаг болон тэдгээрийн нэгдмэл сонирхолтой этгээд эзэмшиж байгаа компанид Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлд заасны дагуу ТЕЗ-аас шууд хяналт тавих боломжгүй тул Компанийн тухай хуульд нийцүүлэн ТУЗ болон компанийн дотоод хяналтын нэгж хяналт хэрэгжүүлэх шаардлагатай.

Дүгнэлт: Төсвийн тухай хуулийн дээрх зохицуулалтаас үзвэл Шилэн дансны тухай хуулийн үйлчлэлд хамаарах бүх субъектэд ТЕЗ-ийн дотоод хяналтыг хэрэгжүүлэхээр байна.

Мөн 3.1.3-т хамаарах хяналтын багц буюу түүнээс дээш хэмжээний хувьцааг нь төр, орон нутаг болон тэдгээрийн нэгдмэл сонирхолтой этгээд эзэмшиж байгаа компанид дотоод аудитын нэгжээс хэрэгжүүлж буй хяналт нь нэгдсэн арга зүй, зааваргүй тул үр нөлөө бага байна. Хяналт тавих арга хэлбэрийг нарийвчлан журамласнаар хуулийн хэрэгжилт сайжирна.

Зөвлөмж: Үндэсний аудитын газрын зөвлөмжийн дагуу Шилэн дансны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсэгт холбогдох өөрчлөлтийг хийх замаар хуулийн хэрэгжилтэд дотоод хяналтыг бүрэн гүйцэд хийх тогтолцоог бүрдүүлэх нь зөв байна.

Дотоод хяналт тавих арга хэлбэрийг нарийвчлан журамласнаар хуулийн хэрэгжилт сайжрах тул холбогдох журмыг батлан мөрдүүлэх эрхийг хуулиар олгох зохицуулалтыг бий болгох шаардлагатай байна.

3.2.6. 10 дугаар зүйлийн хэрэгжилтийн үнэлгээний талаар:

10 дугаар зүйл.Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага

10.1-д “Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.” гэж заасан.

10 дугаар зүйлийн хэрэгжилтийн үнэлгээг хууль тогтоомж хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш зорилгод хүрсэн түвшингээр нь авч үзэхэд хууль хэрэгжилтийн явцад ихээхэн учир дутагдалтай буюу хуулийн зорилтод хүрээгүй болох нь тогтоогдож байна.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 06 дугаар сарын 04-ний өдрийн 260 дугаар тогтоолоор “Төрийн өмчит үйлдвэрийн газар, төрийн өмчит компанийн захиралтай контракт байгуулах, дүгнэх журам”-ыг баталсан бөгөөд тус журмын дагуу ТӨБЗГ нь төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн гүйцэтгэх захиралтай контракт байгуулан, контрактыг дүгнэн ажилладаг. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас нийт төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн захирал нарт Шилэн дансны тухай хууль тогтоомжийг мөрдөж ажиллах талаар үүрэг даалгавар, чиглэл өгч ажилладаг. Гэвч үүнээс өөр хариуцлагын тогтолцоо тодорхойгүй байдаг.

Тодруулбал, хуулийн үйлчлэх хүрээг хуулиар тогтоохдоо дараахь этгээдүүдийг батгаасан байдаг. Үүнд:

3.1.1.төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд;

3.1.2.төрийн өмчит үйлдвэрийн газар;

3.1.3.хяналтын багц буюу түүнээс дээш хэмжээний хувьцааг нь төр, орон нутаг болон тэдгээрийн нэгдмэл сонирхолтой этгээд эзэмшиж байгаа компани;

3.1.4.улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөр, арга хэмжээ, ажил, үйлчилгээ гүйцэтгэж байгаа аж ахуйн нэгж, байгууллага;

3.1.5.төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг хууль тогтоомж, гэрээний үндсэн дээр гүйцэтгэгч.

Гэтэл хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсэгт энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол зөвхөн Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэхээр зохицуулсан нь Төрийн албаны тухай хуулийн үйлчлэлд хамаарахгүй этгээдүүдэд хариуцлага хүлээлгэх боломжгүй болгосон байна.

Хуулийн энэхүү алдаа дутагдалтай байдалд Үндэсний аудитын газраас дараахь **Дүгнэлт, Зөвлөмжүүдийг** гаргасан байна. Үүнд:

1. Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээ, ажил, үйлчилгээ гүйцэтгэж байгаа аж ахуй нэгж, байгууллага болон төрийн чиг үүрэгт хамаарах ажил үйлчилгээг гэрээний үндсэн дээр гүйцэтгэгчийн мэдээлэх үүргийн хэрэгжилтэд хяналт тавих байгууллага, албан тушаалтан, хүлээлгэх хариуцлагыг хуульд тодорхой тусгаагүйгээс дээрх байгууллагууд нэгдсэн цахим хуудаст бүрэн хамрагдахгүй байна.

2. Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4, 3.1.5-д хамаарах арван сая төгрөгөөс дээш үнийн дүнгээр улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөр, арга хэмжээ, ажил, үйлчилгээ гүйцэтгэгч ААНБ-ууд Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст бүрэн хамрагдаагүй, төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг гүйцэтгэгчид хуульд заасан мэдээллийг мэдээлээгүй нь санхүүжилт олгосон байгууллагаас хяналт тавих, хариуцлага хүлээлгэх зохицуулалтгүйтэй холбоотой байх тул уг асуудлыг хууль, журамд нэмж зохицуулах шаардлагатай байна.

Иймд Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3, 3.1.4, 3.1.5-д хамаарах хуулийн этгээдийн шилэн дансны үйл ажиллагаанд хяналт тавих этгээдийг оновчтой тодорхойлж, хүлээлгэх хариуцлагыг Шилэн дансны тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомжтой уялдуулах талаар арга хэмжээ авах зэрэг болно.

3. Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1-д заасны дагуу Хөдөлмөрийн гэрээ, контракт байгуулан ажилладаг төрийн үйлчилгээний албан

хаагчид Шилэн дансны тухай хуулийн дагуу холбогдох мэдээллийг байршуулах үүрэг хүлээсэн байдаг.

Гэтэл тус хуулийн 10 дугаар зүйлийн 10.1-т “Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ” гэж зааснаас Хөдөлмөрийн гэрээ, контрактаар ажилладаг төрийн үйлчилгээний албан хаагчид Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж ажиллагаагүй тохиолдолд дээрх заалтын дагуу хариуцлага тооцох эрх зүйн зохицуулалтыг орхигдуулжээ.

4. Нийслэл болон зарим аймгийн ТЕЗ-ийн дотоод хяналт, шалгалтыг хангалтгүй хэрэгжүүлж байгаа нь Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд холбогдох хяналтыг хэрэгжүүлэх давтамж, хугацаа болон хяналтын чиг үүргээ бүрэн хэрэгжүүлээгүй албан тушаалтанд хариуцлага тооцох эрх зүйн зохицуулалтгүйтэй холбоотой байна.

Зөвлөмж: Шилэн дансны тухай хуулийн үйлчлэх хүрээнд хамаарч буй үүрэг хүлээсэн этгээд нь Төрийн албаны тухай хуулийн үйлчлэх хүрээний этгээд болон Хөдөлмөрийн тухай хүрээнд хамаарах этгээд байх тул хуулийн хариуцлагыг “Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай болон Хөдөлмөрийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ” гэж өөрчлөх.

---oOo---

Үгийн товчлол

АТГ	Авлигатай тэмцэх газар
ААНБ	Аж ахуй нэгж байгууллага
БСШУСЯ	Боловсрол соёл, шинжлэх ухаан, спортын яам
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ЗГХЭГ	Засгийн газрын хэрэг эрхлэх газар
ЗГСУМС	Засгийн газрын санхүүгийн удирдлагын мэдээллийн систем
НББ	Нягтлан бодох бүртгэл
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
НДС	Нийгмийн даатгалын сан
ОНӨАА	Орон нутгийн өмчит аж ахуй
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ИНХ	Иргэдийн нийтийн хурал
ИТХ	Иргэдийн төлөөлөгчийн хурал
ШД	Шилэн данс
ТББ	Төрийн бус байгууллага
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ХАА	Хөдөө аж ахуй
ХОМ	Хөрөнгө орлогын мэдүүлэг
ТӨҮГ	Төрийн өмчит үйлчилгээний газар
ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл
ХШУДАГ	Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар
ХШҮ	Хяналт шинжилгээний үнэлгээ